



# ДАРГААГИЙН ЗОГСООЛ ЧЕХ УЛС

Чех Улсад амьдрах хүсэлтэй гадаадын  
иргэдэд зориулсан мэдээлэл

2020 он



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



# ДАРААГИЙН ЗОГСООЛ – ЧЕХ УЛС

Энэхүү товхимол нь Чех Улсад удаан хугацаагаар суурьших зорилготой ирж байгаа гуравдагч орны иргэдэд зориулагдсан бөгөөд “Дараагийн зогсоол - Чех Улс” богино хэмжээний баримтат кино, гадаадын иргэдийн Чех Улсад орж ирсний дараа хамрагддаг дасан зохицох, интеграцчилалын дамжаатай уялдуулан бэлтгэсэн болно.

Эдгээр танилцуулга нь Чех Улсад амьдарч буй гадаадын иргэдийг интеграцчилах, тэдний Чех Улсад эдлэх эрх үүрэг, Чех орны төдийгүй амьдарч буй тухайн бус нутгийнхаа талаар бодитой ойлголт олж авахад нь туслана. Чех Улсад хууль зөрчилгүйгээр амьдрах нөхцлийн талаар үнэн зөв мэдээлэл түгээх нь үүсч болзошгүй сөрөг үзэгдлээс сэргийлэх зорилго агуулдаг. Чех Улсад оршин суухтай холбогдох ихэнх асуудлыг хөөцөлдөхөд ямар нэг бэрхшээл саад үгүй тул энэхүү мэдээллийг шинээр ирж буй гадаадын иргэдэд хүргүүлэх нь тэдний бие даасан, бусдаас хараат бус байдлыг хөхүүлэн дэмжиж байгаагийн илрэл юм. Шаардлагатай гэж үзвэл үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг төрийн тус байгууллагууд (ТББ), Интеграцчилалын төвүүдэд хандах боломжтой.


“Дараагийн зогсоол – Чех Улс” мэдээллийн товхимол, киного Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын газар, Интеграцчилалын төвүүд, “Слово 21” болон төрийн бус байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн мэргэжлийн ажлын баг бэлтгэн боловсруулав.

© Slovo 21, z. s., 2020

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Нийтлэгч байгууллагын бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр уг товхимлыг бүрнээр болон хэсэгчлэн цахим, хэвлэмэл ямарваа нэгэн хэлбэрээр олшруулах, хувилан тараахыг хориглоно.

Нэмж засварласан дөрөв дэх хэвлэл

ISBN 978-80-88301-28-8




MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Гадаадын иргэдийг интеграцчилах энэхүү төслийг Бүгд Найрамдах Чех Улсын Дотоод хэргийн яамнаас санхүүжүүлж, “Слово 21” нийгэмлэг хэрэгжүүлж байна.

# ГАРЧИГ

Дараагийн зогсоол – Чех улс .....	4
Чех улсад явахаар төлөвлөж байна .....	7
Чех улсад ирсний дараа .....	27
Юуг анхаарах вэ? Ямар хүндрэл бэрхшээл тохиолдож болох вэ?.....	41
Чех улсын чухал зарим байгууллагуудын холбоо барих хаяг, утас.....	46



# ДАРААГИЙН ЗОГСООЛ – ЧЕХ УЛС

Плзень хотын захад орших “Ческе удоли” хиймэл  
нуурын эрэгт нар жаргаж байгаа нь

## ЭНЭХҮҮ ТОВХИМОЛ ХЭНД ЗОРИУЛАГДСАН БЭ?

Тус товхимол нь Чех Улсад 90-ээс дээш хоногийн хугацаагаар зорчихтой холбогдуудан удаан хугацааны виз эсвэл удаан хугацааны зөвшөөрөл авах хүсэлт гаргах санаатай Европын Холбоо (ЕХ)-ноос бусад орны иргэдэд ЗОРИУЛАГДСАН.

## ЭНЭХҮҮ ТОВХИМОЛ ХЭНД ЗОРИУЛАГДААГҮЙ ВЭ?

Тус товхимол нь Европын Холбооны иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, Шенгений богино хугацааны виз эсвэл байнга оршин суух зөвшөөрөл хүсэгчдэд ЗОРИУЛАГДААГҮЙ!

## УДААН ХУГАЦААНЫ ВИЗ ГЭЖ ЮУ ВЭ?

Чех Улсад анх удаа 90-ээс дээш хоногийн хугацаагаар зорчих гэж буй хүмүүсийн мэдүүлдэг хамгийн түгээмэл виз, Чех Улсад 90-ээс дээш хоногоор оршин суух эрх олгодог 1 жилээс илүүгүй хугацаанд хүчинтэй визийг удаан хугацааны виз (цаашид “виз” гэнэ) гэнэ. Хэрэв та Чех Улсад цаашид ч амьдарч, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа буюу өөрөөр хэлбэл Чех Улсад ирсэн анхны зорилгоо өөрчлөхгүй тохиолдолд Чех Улсад удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргаж Чех Улсад оршин суух хугацаагаа сунгуулах боломжтой. **Удаан хугацааны виз нь гадаад паспортод нааж олгодог наалт хэлбэртэй.**

## УДААН ХУГАЦААНЫ ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Зарим нэг онцгой тохиолдолд Чех Улсад анх орж ирэхээсээ өмнө хүсэх боломжтой хэдий ч ихэвчлэн Чех Улсад оршин сууж байгаа хугацаандаа удаан хугацааны визтэйгээ залгуулан хүсдэг тус улсад оршин суух эрхийг удаан хугацааны оршин суух зөвшөөрөл (цаашид “удаан хугацааны оршин суух зөвшөөрөл” гэнэ) гэж нэрлэнэ. Үүнийг 2-оос дээшгүй жилийн хугацаагаар олгодог бөгөөд **биеийн давцахгүй өгөгдөл агуулсан чиптэй карт хэлбэртэй байдаг.**

**Удаан хугацааны виз, удаан хугацааны оршин суух зөвшөөрөл хоорондын ялгааг сайтар ялгаж сурагтун! Энэ нэр томъёог зөв ойлгож байх нь хэзээ ч илүүдэхгүй!**

## **ХЭН ТАНЫ ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭДЭГ ВЭ?**

Виз олгох эсэх асуудлыг таны виз мэдүүлсэн ЭСЯ шийдвэрлэнэ. Удаан хугацааны виз, удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах таны хүсэлтийг хүлээн авсан ЭСЯ нь БНЧУ-ын Дотоод хэргийн яаманд явуулж шийдвэрлүүлдэг.





# ЧЕХ УЛСАД ЯВАХААР ТӨЛӨВЛӨЖ БАЙНА

Чески Крумлов дахь цайз шилтгээн

## ЧЕХ УЛСАД СУРГУУЛЬД СУРАХ ХҮСЭЛТЭЙ ТОХИОЛДОЛД

Хэрэв та Чех Улсад суралцах хүсэлтэй мөн өөрийн сонирхож байгаа дээд эсвэл гүнзгий мэргэших сургуулиа нэгэнт сонгосон бол дараах мэдээллийг нягталж үзнэ үү.


- Гадаадын иргэд Чех Улсад оршин суух тухай хуулийн дагуу “сурах” төрөлд хамрагдах уу, аль эсвэл боловсролын өөр төрөлд хамрагдах уу? (Чех Улс дахь сургуулиудын сургалтын төрөл, оршин суух зорилгын талаарх мэдээллийг [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим хуудсаар орж нягтална уу.)
- Чех Улсад ямар хугацаатай суралцах вэ? (Чех Улсын сургуулиас лавлана)

Хэрэв та Чех Улсад 90-ээс дээш хоногийн хугацаагаар сурахаар төлөвлөж байгаа бол сургалтын төрлөөс хамааран БНЧУ-ын ЭСЯ-нд дараах төрлийн виз мэдүүлж, оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах эрхтэй:

- **“сурах” зорилгоор олгох удаан хугацааны оршин суух зөвшөөрөл** авах хүсэлтийг хуульд заасны дагуу сурах зорилгоор Чех Улсад 3 сараас илүү хугацаагаар байх гадаадын иргэн БНЧУ-ын ЭСЯ-нд гаргах эрхтэй. Энэ нь дунд болон хөгжим бүжгийн дунд сургуулиудын солилцооны шугамаар эсвэл мэргэжлийн төлбөртэй дадлагын сургалтад хамаарахгүй.

Хүсэлтийн хариу 60 орчим хоногийн дараа гарах бөгөөд хариуг нь БНЧУ-ын ЭСЯ-аас тантай холбоо барьж мэдэгдэнэ. Хэрэв та Чех Улсад визгүй зорчих эрхтэй бол нааштай хариу гарсан даруйд Чех Улсад визгүй орж ирж болно. Харин визтэй зорчих тохиолдолд БНЧУ-ын ЭСЯ-аас танд “оршин суух зөвшөөрөл авах виз” дарж өгнө. Чех Улсад орж ирээд ажлын 3 хоногийн дотор бүртгүүлэх, оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгуулахын тулд биеийн давцахгүй өгөгдөл авахуулах зорилгоор Дотоод хэргийн яамны иргэд хүлээн авах төвд очих үүрэгтэй. Бэлэн болсон цахим үнэмлэхийг мөнхүү газраас очиж авна.

- **“сурах” зорилгоор олгох удаан хугацааны оршин суух зөвшөөрлийг** БНЧУ-д оршин суух тухай хуульд заасан төрөлд нийцэж буй сургал-





тад хамрагдсан гадаадын иргэн БНЧУ-ын ЭСЯ-д Чех Улсад 3-аас дээш сарын хугацааны виз мэдүүлэх эрхтэй. Дунд эсвэл хөгжим бүжгийн дунд сургуулийн сургалтад хамрагдаж буй тохиолдолд заавал солилцооны шугамаар байх албагүй бөгөөд мэргэжлийн төлбөртэй дадлага байж болно.

Хүсэлтийн хариу 60 орчим хоногийн дараа гарах бөгөөд хариуг нь БНЧУ-ын ЭСЯ-аас тантай холбоо барьж мэдэгдэх ба нааштай шийдэгдсэн тохиолдолд таны паспортод виз нааж өгнө. Чех Улсад орж ирээд ажлын 3 хоногийн дотор гадаадын иргэдийн асуудлыг эрхэлсэн цагдаагийн газарт бүртгүүлэх үүрэгтэй.

• **“бусад” зорилгоор олгох удаан хугацааны оршин суух виз** (үүнд сургалтын өөр бусад төрөл ч хамаарна) Чех Улсад 3-аас дээш сарын хугацаагаар, сургалт нь Гадаадын иргэд БНЧУ-д оршин суух тухай хуульд заасан төрөл зүйлд хамрагдаагүй гадаадын иргэн БНЧУ-ын ЭСЯ-д мэдүүлэх эрхтэй.

Мэдүүлгийн хариу 90-120 орчим хоногийн дараа гарах боловч зарим нэг нөхцөл байдлаас шалтгаалан заасан хугацаанаасаа хэтрэх тохиолдол гардаг. Хариу нааштай гарвал БНЧУ-ын ЭСЯ-аас тантай холбоо барьж мэдэгдэх ба таны паспортод виз нааж өгнө. Чех Улсад орж ирээд ажлын 3 хоногийн дотор гадаадын иргэдийн асуудлыг эрхэлсэн цагдаагийн газарт бүртгүүлэх үүрэгтэй.

Хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж, гадаад улсаас олгосон бичиг баримтыг чех хэл рүү орчуулсан албан ёсны орчуулгын хамт хавсаргана. Үүнд,

- Гадаад паспорт,
- Сургууль, боловсролын байгууллагад элссэн тухай тодорхойлолт,
- 1 хувь цээж зураг,
- Чех Улсад суух байрны бичиг,
- Санхүүгийн хангалттай эх үүсвэртэй бөгөөд түүнийгээ Чех Улсын нутаг дэвсгэрт ашиглах боломжтойг гэрчилсэн баримт,
- Харьяат эсвэл сүүлийн 3 жил тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар амьдарсан улсын эрх бүхий байгууллагаас олгосон ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаа (БНЧУ-ын ЭСЯ-ны хүсэлтээр бүрдүүлнэ),
- халдварт өвчин тараахаас сэргийлэх нөхцөл болзлыг хангасан тухай тодорхойлолт (БНЧУ-ын ЭСЯ-ны хүсэлтээр бүрдүүлнэ),
- Визийн хариу нааштай гарсан тохиолдолд ЭСЯ-нд Чех Улсад даатгалтай болохыг гэрчилсэн бичгийг бүрдүүлнэ.

Хүсэлт болон мэдүүлэг гаргах, сургалтад хамрагдах, Чех Улсад гадаадын иргэдийн эрх үүрэг хэрхэн зохицуулагддаг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим хуудаснаас өөрсдөө сайтар судлах **шаардлагатай**.

## ТА ДАРААХ ЗҮЙЛД АНХААРЛАА ХАНДУУЛНА УУ.

- Та удаан хугацааны виз авсан тохиолдолд оюутны байрнаас өөрийг тань бүртгүүлээгүй бол Чех Улсад орж ирээд ажлын 3 хоногийн дотор гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газарт бүртгүүлэх үүрэгтэй.
- Хэрэв та Чех Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл авахаар ирсэн бол тус улсад орж ирээд ажлын 3 хоногийн дотор Дотоод хэргийн яаманд очиж цахим үнэмлэх олгоход шаардагдах биеийн давхцахгүй өгөгдлөө авахуулах үүрэгтэй.
- Хэрэв та сурах зорилгоор виз эсвэл оршин суух зөвшөөрөл авсан бол Чех Улсад байх хугацааныхаа туршид **оюутан статустай байхаас гадна бодитойгоор сургуульд суралцаж**, виз, оршин суух зөвшөөрлийнхөө зорилгыг зөрчихгүй байх үүрэгтэй. **Гадаадын иргэд сургуульд суралцахын зэрэгцээ бизнес эрхлэх эрхтэй. Харин зөвхөн дунд сургууль, хөгжим бүжгийн дунд сургууль, гүнзгий мэргэших, их, дээд сургуулийн магадлан итгэмжлэгдсэн өдрийн ангийн хөтөлбөрт хамрагдсан тохиолдолд хөдөлмөр эрхлэх эрхтэй.** Оршин суух зөвшөөрлийн үндсэн зорилго нь ямагт бодит байдалтайгаа нийцэх буюу сургуульд сурах шаардлагатай.
- **Сургуулиа солих** тохиолдолд нэг сургуулиас нөгөө сургууль руу завсардахгүй шилжих шаардлагатай. Таныг сургуулиас гарсан тухай хуучин сургуулиас тань Дотоод хэргийн яаманд мэдэгдэх ба харин шинэ сургуульд орсон тухайгаа та өөрөө мэдэгдэх үүрэгтэй. Ямар нэг өөрчлөлтийг Дотоод хэргийн яамны хэлтэст 3 хоногийн дотор мэдэгдэх дүрэмтэй.



- Сургуульд сурч байгаа тухай тодорхойлолтод зуны амралт, шалгалт, улсын шалгалт өгснөөр сургуулиа төгсөх хүртэлх нийт хугацаа бүхэлдээ багтана. Чех Улсад сурч байх хугацаандаа зуныхаа амралтаар гадаад улсад жуулчлах, нутаг явж амрах боломжтой. Таны оршин суух зөвшөөрөлтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэж байх явцад түр хугацаагаар тус улсаас гарах болсон тохиолдолд Дотоод хэргийн яамны холбогдох хэлтэст мэдэгдэхээс гадна таны нэр дээр ирэх албан захидлаа хүлээн авах асуудлаа зохицуулах шаардлагатай.
- Та **сургуулиасаа хасагдсан** тохиолдолд таны сурч байсан сургууль энэ талаар Дотоод хэргийн яаманд мэдэгдсний үндсэн дээр таны виз эсвэл оршин суух зөвшөөрөл хүчингүй болж болзошгүй.

## ЧЕХ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ХҮСЭЛТЭЙ БАЙНА

Хэрэв та Чех Улсад хөдөлмөр эрхлэх хүсэлтэй бол тус улсад ирэхээсээ өмнө ажлын байраа олж, холбогдох асуудлаа эртнээс зохицуулсан байх шаардлагатай.

**[www.mpsv.cz/web/cz/-/vyhledavani-volnych-pracovnich-mist-pro-cizince](http://www.mpsv.cz/web/cz/-/vyhledavani-volnych-pracovnich-mist-pro-cizince)** цахим хуудаснаас Чех Улс дахь ажлын саналыг **өөрсдөө судалж үзнэ үү.**

### 1. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх тухай

Чех Улсын хөдөлмөрийн зах зээлд амжилттай нэвтрэхийн тулд хүчин төгөлдөр оршин суух зөвшөөрөлтэй байхаас гадна хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх боломжтой эсэхээ судалж мэдэх нь чухал. Чех Улсын хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эсэх нь оршин суух зөвшөөрлийн ангилал, хөдөлмөрийн төрөл, өөр бусад нөхцөл байдлаас шалтгаална.



Хөдөлмөрийн зах зээлд дараах хүмүүс чөлөөтэй нэвтрэчэ. Үүнд,

- ЕХ-ны гишүүн орны иргэд, тэдний гэр бүлийн гишүүд,
- байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд,
- олон улсын хамгаалалд хамрагсад (орогнох эрх авсан эсвэл нэмэлт хамгаалалд хамрагдсад),
- байнга, удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл эсвэл орогнох эрх авсан гадаадын иргэнтэй гэр бүл нэгтгэх зорилгоор ирсэн хүчин төгөлдөр удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд,
- мэргэжлийн чиглэлээр тасралтгүй суралцаж байгаа гадаадын иргэд (жишээ нь, дунд сургуулийн магадлан итгэмжлэгдсэн өдрийн сургалтын хөтөлбөр, хөгжим бүжгийн дунд сургууль, гүнзгий мэргэших сургууль, чех хэлний улсын шалгалт явуулах эрх бүхий хэлний сургууль, магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн өдрийн сургалтын хөтөлбөрийн оюутан; үүнд зуны амралт ч багтана),
- Чех Улсын хууль тогтоомжийн дагуу дунд эсвэл дээд боловсрол эзэмшсэн гадаадын иргэд.

Дээр дурдсан тохиолдолд гадаадын иргэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, ажилтны эсвэл цэнхэр карт авах шаардлагагүй хэдий ч тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суух зөвшөөрөл эсвэл визтэй байх шаардлагатай. Чех Улсад визгүй зорчих нь хөдөлмөр эрхэлж болно гэсэн үг огт биш. Оройтлоо гэхэд өөрийг тань ажилд орсон эхний өдөр ажил олгогч БНЧУ-ын Хөдөлмөрийн товчоонд энэ талаар мэдэгдэх үүрэгтэй.

Ажил олгогч хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх боломжгүй гадаадын иргэнийг ажиллуулах тохиолдолд гадаадын иргэн нь хөдөлмөрийн гэрээ эсвэл ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас гадна хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, ажилтны эсвэл цэнхэр карт авсан байх шаардлагатай.

## **2. Улирлын чанартай хөдөлмөр эрхлэх зорилгоор олгох удаан хугацааны оршин суух зөвшөөрөл**

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, усан үзмийн аж ахуй, аялал жуулчлал зэрэг улирлаас хамаарсан салбарт хөдөлмөр эрхлэх зорилгоор ЧУ-д оршин суух хүсэлтэй гадаадын иргэнд улирлын чанартай хөдөлмөр эрхлэх зорилгоор 90-ээс дээш хоногийн виз олгодог. Энэ ангиллын виз олгоход визний хүчинтэй байх хугацааг заах бөгөөд ЧУ-д оршин суух хугацаа 6 сараас дээшгүй байна.

Хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж, гадаад улсаас олгосон бичиг баримтыг чех хэл рүү орчуулсан албан ёсны орчуулгын хамт хавсаргана. Үүнд,

- Гадаад паспорт,
- БНЧУ-ын Хөдөлмөрийн товчооны аймгийн эсвэл Прага хотын салбараас олгосон хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл гараагүй тохиолдолд гаргасан хүсэлтийн дугаар, БНЧУ-ын Хөдөлмөрийн товчооны аль салбар хүсэлтийг хянан шийдвэрлэж байгаа тухай мэдээлэл,
- 1 хувь цээж зураг,
- Чех Улсад суух байрны бичиг,
- Ажил олгогч нь гадаадын иргэнийг байраар хангаж байгаа эсвэл байр олоход зуучилж байгаа тохиолдолд ажил олгогчийн цалин хөлсний тодорхойлолт,
- Харьяат эсвэл сүүлийн 3 жил тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар амьдарсан улсын эрх бүхий байгууллагаас олгосон ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаа (БНЧУ-ын ЭСЯ-ны хүсэлтээр бүрдүүлнэ),
- халдварт өвчин тараахаас сэргийлэх нөхцөл болзлыг хангасан тухай тодорхойлолт (БНЧУ-ын ЭСЯ-ны хүсэлтээр бүрдүүлнэ),
- Визийн хариу нааштай гарсан тохиолдолд ЭСЯ-нд Чех Улсад даатгалтай болохыг гэрчилсэн бичгийг бүрдүүлнэ.

### 3. Удаан хугацааны оршин суух зөвшөөрөл – ажилтны карт

**Ажилтны карт** гэдэг нь хөдөлмөр эрхлэх зорилгоор удаан хугацааны оршин суух **зөвшөөрлийн тусгай нэгэн төрөл юм.** Энэ карт нь **дээд тал нь 2 жилийн хугацаатай оршин суух зөвшөөрөл, тодорхой орон тоон дээр ажиллах боломжийг хослуулан олгодог ороо онцлог юм.**

Ажилтны карт олгох үндсэн нөхцөл, болзол:

- ажил олгогч нь ажилтны карт эзэмшигч гадаадын иргэн ажиллаж болох орон тоо суларсан зар өгсөн,



- сул орон тоонд ЧУ-ын эсвэл ЕХ-ы гишүүн орны иргэн эсхүл хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтэрч болох гадаадын иргэн ороогүй,
- гадаадын иргэн тухайн орон тоонд тохирох мэргэжлийн шаардлага хангасан гэдгээ нотолсон,
- сарын нийт цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй, долоо хоногийн ажлын цагийг хөдөлмөрийн гэрээ эсвэл ажил гүйцэтгэх гэрээнд зааснаар хамгийн багадаа 15 цаг байхаар тодорхойлсон.

Хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж, гадаад улсаас олгосон бичиг баримтыг чех хэл рүү орчуулсан албан ёсны орчуулгын хамт хавсаргана. Үүнд,

- Гадаад паспорт,
- 1 хувь цээж зураг,
- Ажилтны карт эзэмшигчийн албан тушаалын дугаар,
- Хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх тухай гэрээ эсвэл хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай гэрээ,
- Боловсролын гэрчилгээ, мэргэжлийн нарийн ур чадвар шаардагдах тохиолдолд энэ чиглэлээр олгосон гэрчилгээ, тодорхойлолт. Чех Улсын Боловсролын яамнаас шаардсан тохиолдолд гадаадад эзэмшсэн боловсролын бичиг баримтыг дүйцүүлэн, хүлээн зөвшөөрүүлсэн тухай баримтыг бүрдүүлэх,





- Чех Улсад суух байрны бичиг,
- Харьяат эсвэл сүүлийн 3 жил тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар амьдарсан улсын эрх бүхий байгууллагаас олгосон ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаа (БНЧУ-ын ЭСЯ, хүсэлтийг ЧУ-д гаргасан тохиолдолд БНЧУ-ын Дотоод хэргийн яамны хүсэлтээр бүрдүүлнэ). Олон улсын гэрээнд уг үүргээс чөлөөлөөгүй бол ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаанд консулын баталгаажуулалт эсвэл апостиль гэрчилгээ хийлгэх шаардлагатай.
- халдварт өвчин тараахаас сэргийлэх нөхцөл болзлыг хангасан тухай тодорхойлолт (БНЧУ-ын ЭСЯ, хүсэлтийг ЧУ-д гаргасан тохиолдолд БНЧУ-ын Дотоод хэргийн яамны хүсэлтээр бүрдүүлнэ).
- Хүсэлтийн хариу нааштай гарсан тохиолдолд ЭСЯ-нд Чех Улсад ажил орох өдрийг хүртэл хугацаанд даатгалтай болохыг гэрчилсэн бичгийг бүрдүүлнэ. Ажилд орсон өдрөөс эхлэн ажилтан болох тул нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдаж эхэлнэ.

БНЧУ-ын ЭСЯ-нд хүсэлт гаргах үйлчилгээний хураамжийг тухайн улсын мөнгөний ханшинд шилжүүлж төлнө. Хүсэлтээ ЧУ-ын нутаг дэвсгэрт Дотоод хэргийн яаманд гаргасан тохиолдолд үйлчилгээний хураамжийг шуудан зэрэг үйлчилгээний газруудад худалддаг улсын тэмдэгтээр төлнө. Үйлчилгээний хураамжийн хэмжээг Дотоод хэргийн яамны [www.mvcr.cz/clanek/obcane-tretich-zemi-poplatky.aspx](http://www.mvcr.cz/clanek/obcane-tretich-zemi-poplatky.aspx) цахим хуудаснаас шалгана уу.

Ажлын карт олгуулах хүсэлтийн хариу 60-90 орчим хоногийн дараа гарна. Хариу нааштай гарсан, мөн виз авах шаардлагагүй тохиолдолд Чех Улсад зорчих боломж нээгдэх боловч ЧУ-д визгүй оршин суух 90 хоногийн хугацааг хэтрүүлж болохгүй. Виз авах шаардлагатай тохиолдолд БНЧУ-ын ЭСЯ таны паспортод “оршин суух зөвшөөрөл авах зориулалттай виз” нааж өгнө. Чех Улсад орж ирээд ажлын 3 хоногт багтаж тус улсын Дотоод хэргийн яамны зохих хэлтэст хандаж цахим үнэмлэх олгоход шаардагдах биеийн давхцахгүй өгөгдлөө авахуулах үүрэгтэй. Бэлэн болсон цахим үнэмлэх буюу ажилтны картаа мөнхүү газраас очиж авна.

Ажилтны карт эзэмшигч этгээд албан тушаалаа солих, өөр алба нэмж хаших эсвэл ажлаа (ажил олгогчоо) солих тохиолдолд юун түрүүнд Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын бодлогын газарт энэхүү өөрчлөлтийн тухай мэдэгдэх үүрэгтэй. ДХЯ-аас мэдэгдэл хүлээн авсан тухай хариу мэдэгдтэл шинэ албан тушаалд очих, ажлаа солих, шинэ ажилд орохыг зөвшөөрөхгүй. Хөдөлмөрийн тухай хуулинд заасан онцгой тохиолдлоос бусад үед ажлаа солих, шинэ ажилд орох зэрэг мэдэгдлийг анхны ажлын картаа авснаас 6 сар өнгөрсний дараа л гаргах боломжтой.

Хэрэв гадаадын иргэн ажил, албан тушаалаа өөрчлөхгүй зөвхөн ажилтны картныхаа хугацааг сунгуулах бол БНЧУ-ын Дотоод хэргийн яаманд картны хүчинтэй хугацаа дуусахаас дээд тал нь 120 хоногийн өмнө, доод тал нь сүүлийн өдөр ажилтны картныхаа хугацааг сунгуулах хүсэлт гаргана. Ийм тохиолдолд БНЧУ-ын Хөдөлмөрийн товчоо хөдөлмөрийн зах зээл дэх нөхцөл байдлыг харгалзан тухайн гадаадын иргэнийг цаашид ажиллуулах эсэх шийдвэр гаргана.

## **Гадаадын иргэн хөдөлмөр эрхлэх зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй байх ба**

**а) хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй эсвэл**

**б) хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан тохиолдолд**

**ажилтны карт нь зөвхөн удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийг орлоно.**

Зарим нэг тохиолдолд хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг БНЧУ-ын Хөдөлмөрийн товчооноос олгодог.

Хөдөлмөр эрхлэх, оршин суух зөвшөөрлийг агуулдаг ажилтны карт эсвэл зөвхөн оршин суух зөвшөөрөл агуулдаг ажилтны карт нь хоорондоо ямар ялгаатай болохыг, мөн ажилтны карт олгуулах хүсэлт гаргахдаа бүрдүүлэх материал, цаанаас тавигддаг нөхцөл, болзлын талаарх мэдээллийг **[www.mvcr.cz/clanek/zamestnanecka-karta](http://www.mvcr.cz/clanek/zamestnanecka-karta)** цахим хуудаснаас сайтар нягталж судлах шаардлагатай.

Чех Улсад ажилтны карт эзэмшигчдэд тохирох ажлын байрны саналыг Чех Улсын Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны **[www.mpsv.cz/web/cz/hledani-volnych-mist](http://www.mpsv.cz/web/cz/hledani-volnych-mist)** цахим хуудаснаас **өөрсдөө үзнэ үү.**

## **ДАРААХ ЗҮЙЛИЙГ МАРТУУЗАЙ!**

- Ажилтны карт нь хөдөлмөр эрхлэх, оршин суух зөвшөөрлийг агуулдаг буюу өөрөөр хэлбэл 1 картаар 2 эрх эдлэнэ гэсэн үг юм! Зарим нэг онцгой тохиолдолд БНЧУ-ын Хөдөлмөрийн товчоо хөдөлмөр эрхлэх тусгай зөвшөөрөл олгодог. Хэрэв та хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан аль эсвэл тус улсын хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй бол ажилтны карт нь зөвхөн хөдөлмөр эрхлэх зорилго бүхий удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн үүрэг гүйцэтгэдэг.

- Ажилтны картын хугацааг сунгуулахад тусгай хугацаа үйлчилнэ: хүсэлтийг картын хугацаа дуусахаас дээд тал нь 120 хоногийн өмнө, доод тал нь картын хүчинтэй байх хугацааны сүүлийн өдөр гаргана.
- Тус улсын хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхгүй гадаадын иргэд ажил эсвэл албан тушаалаа солих тохиолдолд тус улсын Дотоод хэргийн яаманд энэ тухайгаа мэдэгдэх шаардлагатай.
- Таны ажилтны карт хүчинтэй байх хугацаанд та ажлаасаа халагдсан эсвэл ажил олгогчтой ажлаас гарах гэрээ байгуулсан тохиолдолд 60 хоногийн дотор ажил олгогчоо өөрчлөх зөвшөөрөл авах хүсэлт гаргах шаардлагатай. Хүсэлт гаргаагүй тохиолдолд **ажилтны карт хүчингүй болно**. Ажил олгогчоо солих болсон тухай мэдэгдэлд таны хөдөлмөрийн гэрээ хүчинтэй хэвээр байгаа эсвэл дуусгавар болсон огноог гэрчилсэн баримт бүрдүүлнэ.
- Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээний нэг хувийг заавал өөртөө авах нь зүйтэй. Ажил олгогчтой байгуулсан, гарын үсэг бүхий баримт бичгээ нэг бүрчлэн нямбай хадгалагтун! Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой аливаа тохиролцоог ямагт бичгээр үйлдэхийг шаардагтун. Гэрээг бүрэн гүйцэд ойлгосон тохиолдолд л гарын үсгээ зур. Бүх төрлийн хөдөлмөрийн гэрээг зөвхөн бичгээр үйлдсэн байх бөгөөд ажлаас халагдах, ажлаас гарах мэдэгдэл, хөдөлмөрийн гэрээ цуцлах гэрээг ч бичгээр үйлдэнэ.
- Хуульд заасны дагуу долоо хоногт 40-өөс доошгүй цаг ажилласан тохиолдолд 2020 оны байдлаар хамгийн багадаа цалингийн доод хэмжээ болох 14 600 крон (647 орчим ам. доллар/544 ЕВРО) эсвэл түүнтэй тэнцэх нэг цагийн 87,30 крон авах эрхтэй.
- Хуульд зааснаар ажил олгогч таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэгтэй тул энэхүү үүргээ биелүүлж байгаа эсэхийг лавлах нь зүйтэй. Эрүүл мэндийн даатгалын үнэмлэхээ ямагт биедээ авч явах шаардлагатай!



- Хүнтэй ёс бус харьцдаг, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, эрүүл мэндэд хортой нөхцөлд ажиллуулж байгаа бол харьяа хөдөлмөр хяналтын газар (холбоо барих хаяг, утас зэрэг мэдээллийг [www.suip.cz](http://www.suip.cz) цахим худаснаас үзнэ үү), интеграцчилалын төв эсвэл төрийн бус байгууллагад хандагтун. Хэрэв та гэрчийн мэдүүлэг өгөхийн зэрэгцээ гарын үсгээ зурсан шаардлагатай бичиг баримтаар нотолж чадвал ажил олгогчийн эсрэг хөдөлмөр хяналтын газарт гомдол гаргаж болно.
- Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл эсвэл ажилтны карттай холбогдох нөхцлийг зөрчсөн, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл эсвэл ажлын картгүй хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд БНЧУ-ын хууль зөрчсөнд тооцно. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, ажлын картад зааснаас өөр албан тушаалд ажилласан тохиолдолд ч хууль зөрчсөнд тооцох бөгөөд улмаар танд болон ажил олгогч этгээдэд өндөр торгууль ноогдуулж болзошгүй. Ажил олгогч таныг үл тоомсорлож цалин хөлсийг тань өгөхгүй болтлоо байдал даамжирч магад. Нэгэнт ийм хэцүү байдалд орсон гадаадын иргэнийн эрх зөрчигддөг тул үүнээс үүдэн олон төрлийн саад бэрхшээл тулгарах аюултай.

#### 4. Удаан хугацааны оршин суух зөвшөөрөл – цэнхэр карт

Цэнхэр карт нь зөвхөн дээд боловсрол эзэмшсэн эсвэл 3-аас доошгүй жилийн сургалттай гүнзгий мэргэших сургууль төгссөн хүмүүст зориулагдсан. Цэнхэр карт авахын тулд хөдөлмөрийн гэрээгээ Чех Улсад орж ирэхээсээ өмнө буюу цэнхэр карт авах хүсэлт гаргахаасаа өмнө байгуулах шаардлагатай.



Хөдөлмөрийн гэрээг нэг жилээс доошгүй хугацаагаар байгуулж долоо хоногийн ажлын цагийг хуульд зааснаар тогтоохоос гадна сарын эсвэл жилийн нийт цалин нь Чех Улсын жилийн нийт цалингийн дундаж хэмжээнээс хамгийн багаар бодоход 1,5 дахин өндөр байх нөхцөлтэй байна.

БНЧУ-ын ЭСЯ-нд хүсэлт гаргах үйлчилгээний хураамжийг тухайн улсын мөнгөн тэмдэгтээр төлнө. Хүсэлтээ ЧУ-ын нутаг дэвсгэрт Дотоод хэргийн яаманд

гаргасан тохиолдолд үйлчилгээний хураамжийг чех кронеор төлөх боловч шуудан зэрэг үйлчилгээний газруудад худалддаг улсын тэмдэгтээр төлнө. Үйлчилгээний хураамжийн хэмжээг Дотоод хэргийн яамны [www.mvcr.cz/clang/obcane-tretich-zemi-poplatky.asp](http://www.mvcr.cz/clang/obcane-tretich-zemi-poplatky.asp) цахим хуудаснаас шалгана уу.

Цэнхэр карт олгуулах хүсэлтийн хариуг 90 орчим хоног хүлээх хэдий ч зарим нэг нөхцөл байдлаас шалтгаалан заасан хугацаанаасаа хэтрэх тохиолдол байдаг. Хариуг БНЧУ-ын ЭСЯ-аас, хүсэлтийг ЧУ-д гаргасан тохиолдолд Дотоод хэргийн яамнаас мэдэгдэнэ. Хариу нааштай гарсан дээрээс нь виз авах шаардлагагүй бол Чех Улсад зорчих боломж нээлттэй. Виз авах шаардлагатай тохиолдолд БНЧУ-ын ЭСЯ таны паспортод “оршин суух зөвшөөрөл авах зориулалттай виз” нааж өгнө. Чех Улсад орж ирээд ажлын 3 хоногийн дотор тус улсын Дотоод хэргийн яамны зохих хэлтэст хандаж цахим үнэмлэх олгоход шаардагдах биеийн давхцахгүй өгөгдлөө авахуулах үүрэгтэй. Бэлэн болсон оршин суух зөвшөөрлийн үнэмлэх буюу цэнхэр картаа мөнхүү газраас очиж авна.

Хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж, гадаад улсаас олгосон бичиг баримтыг чех хэл рүү орчуулсан албан ёсны орчуулгын хамт хавсаргана. Үүнд,

- Гадаад паспорт,
- Чех Улсад суух байрны бичиг,
- 1 хувь цээж зураг,
- Хөдөлмөрийн гэрээ,
- Боловсролын гэрчилгээ, мэргэжлийн нарийн ур чадвар шаардагдах тохиолдолд энэ чиглэлээр олгосон гэрчилгээ, тодорхойлолт. Чех Улсын Боловсролын яамны шаардлагаар гадаадад эзэмшсэн боловсролын бичиг баримтыг дүйцүүлэн, хүлээн зөвшөөрүүлсэн тухай баримтыг бүрдүүлнэ,
- Таны эрхлэх гэж буй ажил тусгай хуулиар зохицуулагддаг мэргэжилд хамаарагдаж байгаа тохиолдолд ийм мэргэжлийн ажил хийхэд тавигддаг шаардлагыг хангасан тухай тодорхойлолт,
- Харьяат эсвэл сүүлийн 3 жил тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар амьдарсан улсын эрх бүхий байгууллагаас олгосон ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаа (БНЧУ-ын ЭСЯ, хүсэлтийг ЧУ-д гаргасан тохиолдолд БНЧУ-ын Дотоод хэргийн яамны хүсэлтээр бүрдүүлнэ). Олон улсын гэрээнд уг үүргээс чөлөөлөөгүй бол ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаанд консулын баталгаажуулалт эсвэл апостиль гэрчилгээ хийлгэх шаардлагатай.
- Халдварт өвчин тараахаас сэргийлэх нөхцөл болзлыг хангасан тухай тодорхойлолт (БНЧУ-ын ЭСЯ, хүсэлтийг ЧУ-д гаргасан тохиолдолд БНЧУ-ын Дотоод хэргийн яамны хүсэлтээр бүрдүүлнэ).

- Визийн хариу нааштай гарсан тохиолдолд ЭСЯ-нд Чех Улсад ажил орох өдрийг хүртэлх хугацаанд даатгалтай болохоо нотлоно. Ажилд орсон өдрөөс эхлэн нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдана.

Хүсэлт гаргахад тавигдах шаардлага, уг сэдэвтэй холбоотой бусад мэдээллийг [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим хуудасны “Гуравдагч орны иргэд” – “Цэнхэр карт” хэсгээс өөрсдөө сайтар судлах **шаардлагатай.**



Чех Улсад цэнхэр карт эзэмшигч гадаадын иргэдэд тохирох ажлын байрны саналыг тус улсын Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны [www.mpsv.cz/web/cz/hledani-volnych-mist-1](http://www.mpsv.cz/web/cz/hledani-volnych-mist-1) цахим хуудаснаас өөрсдөө хайж үзнэ үү.

## Бичиг баримт баталгаажуулах

Ажил олгогчоос ажлын байрны сул орон тоо байгаа гэсэн зард мэргэжлийн нарийн ур чадварын шаардлага тавьсан тохиолдолд гадаадын иргэн нь тухайн орон тоон дээр ажиллах мэргэжлийн нарийн ур чадварын гэрчилгээ бүрдүүлэх үүрэгтэй. Гадаадын иргэн Чех Улсад сургуульд сурахыг хүссэн тохиолдолд ч гадаадад эзэмшсэн боловсролын гэрчилгээгээ дүйцүүлэн баталгаажуулах шаардлагатай. Гадаадад эзэмшсэн боловсролын гэрчилгээг Чех Улсын ижил шатны сургуулиас олгодог гэрчилгээтэй адил түвшинтэй болоод Чех Улсад хүчин төгөлдөр болгуулахын тулд зохих байгууллагаар дүйцүүлэн хүлээн зөвшөөрүүлж, гэрчилгээ авна.

**Боловсрол эзэмшсэн гэрчилгээг баталгаажуулах** гэдэг нь гадаад улсад эзэмшсэн бага, дунд, бүрэн дунд, гүнзгий мэргэших болон дээд боловсролыг Чех Улсад эзэмшүүлдэг боловсролын түвшинтэй адил түвшинтэй гэдгийг албан ёсоор баталгаажуулахыг хэлнэ.



**Бага, дунд, гүнзгий мэргэших сургуулийн** гэрчилгээг **харьяа аймгийн захиргааны боловсролын хэлтэс, Прага хотын хувьд Прага хотын захиргаа баталгаажуулдаг.** Боловсрол эзэмшсэн тухай гэрчилгээг баталгаажуулахад тухайн сургуулийн сургалтын агуулга, хөтөлбөрийн хамт бүрдүүлэх ба олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол боловсрол эзэмшсэн тухай бичиг баримтыг баталгаажуулж, чех хэлний албан ёсны орчуулгыг хавсаргана.

**Их, дээд боловсролын дипломыг дүйцүүлэн хүлээн зөвшөөрүүлэх** асуудлаар сургалтын хөтөлбөр нь агуулгын хувьд ижил түвшний, магадлан итгэмжлэгдсэн **олон нийтийн их, дээд сургуульд** хандах бөгөөд Чех Улстай боловсролын гэрчилгээ харилцан хүлээн зөвшөөрөх олон улсын гэрээ байгуулсан гадаад улсын их, дээд сургуулиас олгосон дипломын хувьд Чех Улсын Боловсрол, залуучууд, биеийн тамирын яаманд хандана.

Гадаадын их, дээд сургуулиас олгосон дипломыг Европын Холбооны гишүүн аль нэг улсад нэгэнт дүйцүүлэн баталгаажуулсан бол Чех Улсад ч хүлээн зөвшөөрч уг боловсролыг ижил түвшинд тооцно.

Баримт бичгээ баталгаажуулах явцдаа **апостиль гэрчилгээ, консулын баталгаажуулалт** гэсэн нэр томъёотой тааралдаж магад. Апостиль гэрчилгээ, консулын баталгаажуулалтын гол зорилго нь баримт бичгийг тухайн улсын хууль хяналтын эсвэл захиргааны байгууллагаас олгосон эсвэл тэдний өмнө үзэглэсэн болохыг гэрчлэнэ гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл баримт бичгийн утга агуулга бус, албан газрын тамга тэмдэг, гарын үсгийн үнэн зөвийг гэрчилнэ. Баталгаажуулалт нь хуурамч баримт бичиг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүднээс үнэн зөв болохыг гэрчлэх гол зорилготой.

Дэлгэрэнгүй мэдээллийг БНЧУ-ын Гадаад харилцааны яамны [www.mzv.cz/jnp/cz/cestujeme/overovani\\_listin/index.html](http://www.mzv.cz/jnp/cz/cestujeme/overovani_listin/index.html) цахим хуудас, Боловсрол, залуучууд, биеийн тамирын яамны [www.msmt.cz/mezinarodni-vztahy/uznavani-vzdelani](http://www.msmt.cz/mezinarodni-vztahy/uznavani-vzdelani) цахим хуудаснаас өөрсдөө судлах шаардлагатай. Дээрхи чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагуудад ч хандах боломжтой.

## **ЧЕХ УЛСАД ХУВИАРАА БИЗНЕС ЭРХЛЭХ ХҮСЭЛТЭЙ БАЙНА**

Чех Улсад бизнес эрхлэх зорилгоор удаан хугацааны визээр орж ирж байгаа гадаадын иргэнийг бизнес эрхлэгч гэж үздэг тул энэ утгаараа үүрэг хүлээдэг. Өөрсдийнхөө боломжоор аль болох их мэдээлэл цуглуулж, судалж, асууж нягтлах хэрэгтэй бөгөөд зөвхөн албан ёсны мэдээллийн эх сурвалжид итгэгтүн.

Чех Улсад анх бизнес эрхлэхээс өөр зорилгоор орж ирсэн гадаадын иргэн дараа нь бизнес эрхлэхийг хүсэх тохиолдолд тус улсад хууль ёсоор 5 жил амьдарсны дараа л оршин суух зорилгоо өөрчлөх хүсэлт гаргах эрхтэй. Чех Улсад анх гэр бүл нэгтгэх зорилгоор ирээд өнөөдрийг хүртэл оршин сууж байгаа тохиолдолд тус улсад 3 ажил амьдарсны дараа оршин суух зорилгоо өөрчлөх хүсэлт гаргана. Чех Улсад бизнес эрхлэхээс өөр зорилгоор оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн оршин суух зорилгоо бодитойгоор биелүүлж байгаагаас гадна хуульд заасан бусад нөхцөл болзлыг хангасан тохиолдолд бизнес эрхлэн боломжтой.

Чех Улсад **хувиараа буюу бизнесийн үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээний** үндсэн дээр эсвэл **хуулийн этгээд (компани)-ийн удирдлагад оролцох гэсэн** хоёр төрлөөр бизнес эрхлэх боломжтой. Аж ахуйн нэгжийн бүртгэлд бүртгэгдсэн, хувиараа бизнес эрхлэх эрх авсан эсвэл бусад хуулийн зохицуулалтаар өөр эрх авсан этгээдийг бизнес эрхлэгчид тооцно.

Хуулийн этгээдийн үйл ажиллагаанд оролцох зорилготой оршин суух зөвшөөрлийг гагцхүү тухайн хуулийн этгээдийн удирдлагын гишүүнд олгодог дүрэмтэй. Компанийн хамтран эзэмшигч, хувь нийлүүлэгч (компанийн удирдлагын гишүүд бус) гадаадын иргэн тухайн компанийн үйл ажиллагааны чиглэлээр ажлын үүрэг даалгавар биелүүлж байгаа тохиолдолд Хөдөлмөрийн товчооноос гаргасан хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах боломжтой хэдий ч түүний үндсэн дээр ажилтны карт авах эрхгүй.

Хөдөлмөр хяналтын газраас хийсэн шалгалтаар зөрчил илэрвэл өндөр торгууль ногдуулдаг тул гадаадын иргэд бизнес эрхлэлт, хөдөлмөр эрхлэлт нь



хоорондоо зарчимын маш их ялгаатай болохыг анхааралдаа авах нь чухал. Хэрэв та бизнес эрхэлж байгаа бол Чех Улсын хууль тогтоомжид заасан нөхцөл болзлыг хангаж байгаа гэдгээ нягтлах шаардлагатай.

Бизнесийн үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээ эсвэл өөр төрлийн эрхийн үндсэн дээр ашиг олох зорилгоор өөрийн нэр дээр өөрөө хариуцан бие даасан орлогын үйл ажиллагаа тасралтгүй явуулж буй иргэн бүрийг бизнес эрхлэгч хэмээн тооцно.

Хөдөлмөрийн харилцааны хүрээнд ажил гүйцэтгэх үүрэг хүлээсэн иргэн бүрийг ажилтанд тооцно. Хөдөлмөрийн харилцааны хүрээнд үүрэг хүлээсэн гэдэг нь ажил олгогч, ажилтан нарын захирах, захирагдах ёсны харилцааны үндсэн дээр ажил олгогчийн нэрийн өмнөөс, түүний даалгавраар ажилтны биечлэн гүйцэтгэх ажлыг хэлнэ.

Компанийн хувь нийлүүлэгч, удирдлага эсвэл хоршооны гишүүн хуулийн этгээдийн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой ажил гүйцэтгэх, үүрэг даалгавар биелүүлэх зэрэг нь хөдөлмөр эрхлэхэд тооцогддог. Чехийн хуулийн этгээд, иргэнтэй байгуулсан гэрээний дагуу үүрэг даалгавар гүйцэтгэхээр гадаадын ажил олгогчоос Чех Улсад томилогдсон гадаадын иргэнийг ч мөн адил хөдөлмөр эрхлэгч гэж үздэг.

Доорхи мэдээлэл ялангуяа **бизнесийн үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээний үндсэн дээр бизнес эрхлэхэд** хамаарна.

Хувиараа орлого олох зорилгоор үйл ажиллагаа явуулдаг буюу өөрөөр хэлбэл бизнес эсвэл эдийн засгийн бусад төрлийн үйл ажиллагаа явууж буй этгээдийг **хувиараа орлого олох үйл ажиллагаа явуулагч (чехээр “osoba samostatně výdělečně činná”, товчилбол “ОСВЧ”/“OSVČ”)** эсвэл **бизнес эрхлэгч** гэж нэрлэдэг. **Бизнес эрхлэлтийг Бизнес эрхлэлтийн тухай хуулиар** зохицуулдаг. Гадаадын иргэд үндсэндээ чех иргэдтэй ижил нөхцөлд бизнес эрхлэх эрхтэй.

## **Бизнес эрхлэх асуудал эрхэлсэн газар**

Уг байгууллага бизнесийн үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээ олгодог. Ийм гэрчилгээ авсан иргэнийг бизнес эрхлэгч буюу хувиараа орлого олох үйл ажиллагаа явуулагч (“ОСВЧ”/“OSVČ”) гэж үзнэ.

## Эрүүл мэндийн даатгал

Бизнес эрхлэгчид эрүүл мэндийн даатгалаа өөрсдөө төлөх үүрэгтэй.

Гадаадад зорчигчдын эрүүл мэндийн даатгалд эх орондоо даатгуулсан этгээд Чех Улсад оршин суух хугацаагаа сунгуулах тохиолдолд гадаадын иргэдэд зориулсан эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ явуулах магадлан итгэмжлэгдсэн даатгалын компанитай эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх даатгалын гэрээ байгуулах шаардлагатай.

## Сумын нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газар ("СНХАЭГ"/"OSSZ")

Нийгмийн хангамжийн асуудлыг Чехийн нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газар (Česká správa sociálního zabezpečení – ČSSZ) хариуцдаг. Бизнес эрхлэгч бүр Сумын нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газарт, Прага хотод Прагийн нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газар ("ПССЗ"/"PSSZ")-т бүртгүүлж, дараа сарын эхний 20 хоногт багтаж нийгмийн хангамжийн урьдчилгааг төлөх үүрэгтэй. Үндсэн ажлын хажуугаар бизнес эрхэлдэг гадаадын иргэн нийгмийн даатгалын шимтгэлийг үндсэн ажлын газраас нь төлж байгаа тохиолдолд урьдчилгаа төлөх шаардлагагүй тул энэ талаар (холбогдох хаяг, утас нь товхимлын эцэст байгаа) интеграцчилалын төв, төрийн бус байгууллагад хандаж зөвлөгөө авбал зүйтэй. Ямарваа нэгэн өөрчлөлтийг дараа сарын эхний 8 хоногт багтаан харьяа НХАЭГ-д мэдэгдэх үүрэгтэй.

Бизнес эрхлэх зорилгоор оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн хэдийгээр тодорхой үйл ажиллагаа явуулаагүй, орлого олоогүй, Чех Улсаас гадуур байгаа ч СНХАЭГ-ийн бүртгэлээс хасуулахгүй байх нь өөрт нь хэрэгтэй.

Гадаадын иргэнд СНХАЭГ-т өр үүссэн тохиолдолд виз, оршин суух зөвшөөрлийг нь хүчингүй болгох эсхүл дахин сунгахаас татгалзаж болзошгүй тул өргүй байхыг хичээгтүн.

## Татварын газар

Бизнесийн үйл ажиллагаа явуулах эрх авсан гадаадын иргэн татварын газарт бүргүүлж, татвар төлөгчийн ("ДИЧ"/"DIČ") дугаар авна.

Бизнес эрхэлдэг хүн бүр орлого зарлагын бүртгэл хөтлөх үүрэгтэй. Энэ бүртгэл нь татварын суурийг тооцолон гаргах үндэс болдог. Бизнес эрхлэгч нь

бүтэн жилийн турш үйл ажиллагаа эрхлээгүй, орлого олоогүй байлаа ч дараа оны 3 дугаар сарын 31-ний дотор багтаж өнгөрсөн оны татварын тайлан гаргах үүрэгтэй. Татварын тайлангийн үндсэн дээр орлогын албан татвар төлөх үүрэг үүснэ.

Бизнес эрхлэх зорилгоор удаан хугацааны виз мэдүүлэхдээ дараах материалыг бүрдүүлж, гадаад улсаас олгосон бичиг баримтыг чех хэл рүү орчуулсан албан ёсны орчуулгын хамт хавсаргана. Үүнд,


- Гадаад паспорт,
- 1 хувь цээж зураг,
- Чех Улсын бизнес эрхлэгчдийн эсвэл аж ахуйн нэгжийн бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээ,
- Чех Улсад оршин суух байрны бичиг,
- Санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байхаас гадна түүнийгээ Чех Улсын нутаг дэвсгэр дээр ашиглах боломжтой болохыг нотлох баримт,
- Харьяат эсвэл сүүлийн 3 жил тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар амьдарсан улсын эрх бүхий байгууллагаас олгосон ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаа (БНЧУ-ын ЭСЯ, хүсэлтийг ЧУ-д гаргасан тохиолдолд БНЧУ-ын Дотоод хэргийн яамны хүсэлтээр бүрдүүлнэ). Олон улсын гэрээнд уг үүргээс чөлөөлөөгүй бол ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаанд консулын баталгаажуулалт эсвэл апостиль гэрчилгээ хийлгэх шаардлагатай.
- халдварт өвчин тараахаас сэргийлэх нөхцөл болзлыг хангасан тухай тодорхойлолт (БНЧУ-ын ЭСЯ, хүсэлтийг ЧУ-д гаргасан тохиолдолд БНЧУ-ын Дотоод хэргийн яамны хүсэлтээр бүрдүүлнэ).
- Чех Улсад оршин суух хугацаанд даатгалтай болохыг гэрчилсэн бичгийг бүрдүүлнэ. Холбогдох байгууллагын хүсэлтээр даатгалын төлбөрийн баримтыг бүрдүүлнэ.

**Виз мэдүүлэхээсээ өмнө** Чех Улсад эрхлэх бизнесийнхээ талаар аль болох дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах нь зүйтэй. Хэрэв бизнесээ дөнгөж эхлүүлж байгаа бол Чех Улсад ирээд хийх ажлаа нэг бүрчлэн бодитоор төлөвлөж үе шатчилсан жагсаалт гаргаж, одоо хамтран ажиллаж байгаа болон цаашид хамтрах боломжтой түншийнхээ талаар мэдээлэл олж авах нь танд тустай байж болох юм. Виз мэдүүлэгч нь ЭСЯ-нд ярилцлагад орох ба худал, итгэл төрүүлэхгүй мэдээлэл өгсөн тохиолдолд ЭСЯ виз олгохоос татгалзана.

Виз мэдүүлэхэд тавигдах шаардлага, энэ асуудлын бусад мэдээллийг [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим хуудасны “Гуравдагч орны иргэд – 90-с дээш хоногийн виз” хэсгээс өөрсдөө **судалж үзнэ үү.**

- Бизнес эрхлэх, хөдөлмөр эрхлэх нь хоорондоо зарчмын хувьд маш их ялгаатай. Хэдийгээр та өөрийгөө бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа гэж үзэж буй ч Чех Улсын хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаад тооцогдож магад. Ийм тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн хууль зөрчсөн гэж үздэг тул өндөр торгууль ногдуулдаг!
- Хэрэв та анх бизнес эрхлэх зорилгоор ирсэн бол Чех Улсад оршин суух хугацаандаа татвар, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалаа өөрөө төлөх үүрэгтэй.
- Хэрэв та Чех Улсад удаан хугацаагаар амьдах хүсэлтэй байвал өөрийгөө гэр бүлийнхнийхээ хамт тэжээх санхүүгийн тогтмол орлоготой гэдгээ нотлох хэрэгтэй. Иймд зөвхөн оршин суух зөвшөөрөл авахын тул бизнес эрхэлж байгаа мэт дүр эсгээд үнэн хэрэгтээ орлогын эх үүсвэргүй байх нь ерөөсөө боломжгүй юм.
- Аль болох олон талын болж өгвөл албан ёсны найдвартай эх үүсвэрээс өөрөө эсвэл Интеграцчилалын төвүүд, төрийн бус байгууллагуудын тусламжтайгаар олж авсан мэдээллээ сайтар судалж нягтал.





# ЧЕХ УЛСАД ИРСНИЙ ДАРАА

Прага хотын Мала страна, Карлын гүүрийн үзэмж

## БҮРТГҮҮЛЭХ ҮҮРЭГ ГЭЖ ЮУГ ХЭЛЭХ ВЭ?

Та Чех Улсын хил нэвтрэн орж ирээд ажлын 3 хоногийн дотор бүртгүүлэх үүрэгтэй!

Удаан хугацааны визтэй гадаадын иргэн Чех Улсад оршин суух хаягийн дагуу харьяалагдах Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газарт бүртгүүлнэ.

Чех Улсад “оршин суух зөвшөөрөл авах зориулалттай виз”-ээр орж ирж байгаа гадаадын иргэн Дотоод хэргийн яамны хэлтэст бүртгүүлэхийн зэрэгцээ биеийн давцахгүй өгөгдөл бүхий оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгоход шаардагдах өгөдлөө авахуулна (цаашид дэлгэрэнгүйг үзнэ үү).

Бүртгүүлэхдээ хүчин төгөлдөр гадаад паспорт, бүртгүүлэх хуудасны хамт бүрдүүлнэ. Бүртгүүлэх хуудсыг Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар эсвэл Дотоод хэргийн яамны хэлтсээс авч бөглөнө.

Бүртгэж буй байцаагч шаардлагатай гэж үзвэл гадаадад зорчигчдын эрүүл мэндийн даатгалын баримтаа шалгуулна.

Оюутны байр, зочид буудалд бүртгүүлсэн гадаадын иргэн дахин бүртгүүлэх шаардлагагүй. Түүнчлэн 15 нас хүрээгүй хүүхдүүд бүртгүүлэхгүй.

Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар, Дотоод хэргийн яамны хэлтсийн хаягийг **www.mvcr.cz/cizinci** цахим хуудасны „Харилцах хаяг“ хэсгээс үзнэ үү.

## БИЕЙН ДАВХЦАХГҮЙ ӨГӨГДӨЛ, ЦАХИМ ҮНЭМЛЭХ ГЭЖ ЮУ ВЭ?

Энэ бүлэгт орсон мэдээлэл удаан хугацааны виз мэдүүлсэн иргэдэд хамаарахгүй!

Биеийн давхцахгүй өгөгдөл гэдэг нь нүүр царай, хурууны хээ, цахим гарын үсэг зэрэг дүрслэлийг хэлэх бөгөөд цахим үнэмлэх нь эдгээр өгөгдлийг агуулдаг. Биеийн давхцахгүй өгөгдлийг Дотоод хэргийн яамны хэлтсүүдэд тусгай зориулалтын тоног төхөөрөмжөөр авдаг бөгөөд мөнхүү газраас бэлэн болсон цахим үнэмлэх олгоно.

Биеийн давхцахгүй өгөгдлийг Чех Улсад удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй гуравдагч орны иргэд авхуулах үүрэгтэй. Чех Улсын нутаг дэвсгэрт визээр орж ирсэн гуравдагч орны иргэд авахуулахгүй. Удаан хугацааны болон байнга оршин суух зөвшөөрлийг биеийн давхцахгүй өгөгдөл бүхий чип суулгасан цахим үнэмлэх хэлбэрээр олгодог.

Гадаадын иргэний өөрийн харьяат улсдаа байхдаа гаргасан удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийг нааштай шийдвэрлэсэн тохиолдолд Чех Улсын хилээр нэвтэрснээс хойш ажлын 3 хоногийн дотор тус улсын Дотоод хэргийн яамны хэлтэст очиж цахим үнэмлэх хийлгэх зорилгоор биеийн давхцахгүй өгөгдөл авахуулна. Очихдоо хүчин төгөлдөр гадаад паспортоо биедээ авч явна.

Гадаадын иргэн биеийн давхцахгүй өгөгдөл авахуулснаас хойш 60-аас дээшгүй хоногийн дотор Дотоод хэргийн яамнаас мэдэгдсний дагуу зохих хэлтэст очиж, улсын тэмдэгтийн хураамж төлж (улсын тэмдэгтийг шуудангаас худалдан авна), үнэмлэх авна. Цахим үнэмлэх олгохдоо биеийн давхцахгүй өгөгдлийг дахин авч өмнөхтэй харьцуулан үздэг.

Оршин суух зөвшөөрлийн үнэмлэх нь таныг Чех Улсад оршин суух эрхтэй болохыг гэрчлэх биеийн байцаалт мөн. Харин Чех Улсын хилээр нэвтрэх, гадаадад зорчих, буцаж орохын тулд цахим үнэмлэхээс гадна гадаад паспортоо ямагт биедээ авч явна.

Гадаадын иргэн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Чех Улсын нутаг дэвсгэрт орж ирээгүй, Дотоод хэргийн яаманд очиж, биеийн давхцахгүй өгөгдөл авахуулаагүй, оршин суух зөвшөөрлийн үнэмлэхээ очиж аваагүй тохиолдолд тус улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн хүсэлт олгох ажиллагааг зогсооно. Хэрэв гадаадын иргэн өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар биеийн давхцахгүй өгөгдлөө цаг тухайд нь авахуулах эсвэл бэлэн болсон үнэмлэхээ очиж авах боломжгүй болсон бол энэ тухайгаа хуульд заасан хугацаанд Дотоод хэргийн яаманд заавал мэдэгдэх шаардлагатай. Мэдэгдээгүй тохиолдолд оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх ажиллагааг зогсоож, улмаар Чех Улсаас гарч явахаас өөр аргагүй байдалд хүрнэ.



Оршин суух зөвшөөрлийн үнэмлэхээ гээгдүүлж, үрэгдүүлэхээс болгоомжлог-  
тун. Шинэ үнэмлэх гаргуулах тохиолдолд өндөр төлбөртэй.

Энэ сэдэвтэй холбогдох мэдээллийг [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим хуудасны  
“Гуравдагч орны иргэд – Биеийн давхцахгүй өгөгдөл” хэсгээс өөрсдөө **суд-  
лана уу.**

## **ӨӨРЧЛӨЛТИЙГ ХЭРХЭН МЭДЭГДЭХ ВЭ?**

Чех Улсад оршин суух хугацаандаа овог, гэр бүлийн байдал, гадаад паспорт,  
оршин суух зөвшөөрлийн үнэмлэхэд бичигдсэн мэдээлэлд өөрчлөлт орох  
тухай бүрт ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

Чех Улсад оршин суугаа хаяг өөрчлөгдөх бүрд 30 хоногийн дотор мэдэгдэх  
үүрэгтэй. Хаяг өөрчлөгдсөн тухайгаа заасан хугацаанд багтаж мэдэгдэх  
шаардлагатай болохыг анхаарна уу. Шинэ орсон байрныхаа шуудангийн хай-  
рцган дээр овог нэрээ заавал бичнэ. Учир нь таны нэр дээр баталгаат албан  
захидал хүргүүлэх тохиолдолд гэрийн хаягаар ирдэг. Хэрэв та эзгүй байж  
таарвал шуудан хүргэгч албан захидлыг хүргээгүй тухай мэдэгдлийг шуудан-  
гийн хайрцганд үлдээдэг бөгөөд уг мэдэгдлийн дагуу захидлаа 10 хоногийн  
дотор шуудангийн салбараас очиж авна. Захидлаа хугацаанд нь амжиж аваа-  
гүй байлаа ч заасан хугацааны сүүлийн өдрөөр захидлыг хүргүүлсэнд тооцно.  
Өөрчлөлт гарах бүрд заасан хугацаандаа багтаж Дотоод хэргийн яамны хэлт-  
эст биечлэн эсвэл бичгээр мэдэгдэх ба ямар хэлбэрээр мэдэгдэж болохыг  
урьдчилан лавлахад илүүдэхгүй. Өөрчлөлт гарсныг гэрчлэх баримтыг эх хуви-  
ар эсвэл баталгаажуулсан хуулбараар биечлэн эсвэл шуудангаар явуулна.

Өөрчлөлт гарсантай холбогдон оршин суух зөвшөөрлийн үнэмлэхээ солиу-  
лах шаардлагатай бол зохих хураамж төлнө.

Энэ сэдэвтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим  
хуудасны “Гуравдагч орны иргэд – Өөрчлөлт мэдэгдэх журам” хэсгээс үзнэ үү.

## **ЧЕХ УЛСАД ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГАА ХЭРХЭН СУНГУУЛАХ ВЭ?**

Чех Улсад удаан хугацааны визээр оршин сууж байгаа гадаадын иргэн оршин  
суух хугацаагаа сунгуулах тохиолдолд визийн хугацаа дуусахаас дээд тал нь  
90 хоногийн, доод тал нь визийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнөх өдөр



визээ сунгуулах хүсэлт гаргана. Гадаадын иргэний Чех Улсад орж ирсэн, цаашдаа байхаар төлөвлөж буй хугацаа нийлээд нэг жилээс хэтрэхгүй тохиолдолд визийн хугацаагаа сунгуулах хүсэлт гаргана. Удаан хугацааны виз сунгуулахад визийн зорилго өөрчлөгдөөгүй хэвээр байх шаардлагатай.

Удаан хугацааны визээр Чех Улсад оршин сууж байгаа гадаадын иргэн оршин суух хугацаагаа сунгуулахдаа өөрийнхөө визтэй уялдуулсны үндсэн дээр анх удаа удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах эрхтэй. Үүнийг визийн хугацаа дуусахаас дээд тал нь 120 хоногийн, доод тал нь визийн хугацаа дуусахын өмнөх ажлын өдөр гаргана. Оршин суух зорилго өөрчлөгдөөгүй хэвээр байх ба Гадаадын иргэд Чех Улсад оршин суух тухай хуульд заасан онцгой тохиолдлоос бусдаар хүсэлтдээ хуульд заасан материалыг бүрэн бүрдүүлж хавсаргана.

Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн үндсэн дээр Чех Улсад амьдарч байгаа гадаадын иргэн оршин суух зөвшөөрлийнхөө хугацааг сунгуулах тохиолдолд визээс оршин суух зөвшөөрөлд шилжихэд үйлчлэх хугацаанд буюу оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас дээд тал нь 120 хоногийн, доод тал нь оршин суух зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусахын өмнөх ажлын өдөр хүсэлтээ гаргана. Энэ тохиолдолд ч мөн адил хуульд заасан материалыг бүрэн бүрдүүлж хүсэлтдээ хавсаргана.

Удаан хугацааны виз, удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн анх удаагийн хүсэлт эсвэл удаан хугацааны оршин суух зөвшөөрөл сунгуулах хүсэлтээ заасан хугацаанд гаргаагүй тохиолдолд Чех Улсад оршин суух эрхийг хүчингүй болгоно.

## **ШЕНГЕНИЙ БОЛОН ЕВРОПЫН ХОЛБООНЫ ОРНУУДАД ХЭРХЭН ЗОРЧИХ ВЭ?**

Шенгений орнууд нь иргэд хилээр шалгалтгүй чөлөөтэй зорчдог улс орнуудыг хамарсан бүс юм. Хилээр хяналт шалгалтгүй чөлөөтэй зорчих явдлыг хамтын нягт ажиллагаа, гадна хилээ хамгаалах хамтарсан журам, цагдаагийн болон хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, хувийн мэдээлэл, өгөгдөл хамгаалал, богино хугацааны виз олгох, Шенгений мэдээллийн системийн тусламжтайгаар мэдээлэл харилцан солилцох зэрэг арга хэмжээгээр зохицуулагддаг юм. Гадаадын иргэн Шенгений аль нэг улсад хууль зөрчсөн тохиолдолд энэ тухай мэдээллийг Шенгений мэдээллийн системд ("СИС"/"SIS") оруулдаг бөгөөд ингэснээр Шенгений бусад орнууд улсынхаа хилээр нэвтрүүлэхгүй байх эсвэл өөрийн нутаг дэвсгэр дээр оршин суух зөвшөөрлийг нь дуусгавар болгох хүртэл арга хэмжээ авдаг.

Шенгений бүсэд дараах орнууд багтдаг:

Австри, Бельги, Герман, Голланд, Грек, Дани, Исланд, Испани, Итали, Латви, Литва, Лихтенштейн, Люксембург, Мальт, Норвег, Польш, Португаль, Словак, Словен, Унгар, Финлянд, Франц, Чех Улс, Швед, Швейцар, Эстони.

ЕХ, ЕЭЗХ-ы бусад гишүүн орнууд буюу Болгар, Ирланд, Кипр, Румын, Хорват зэрэг орнууд Шенгений орнуудын тоонд ордоггүй.

Гуравдагч орны иргэн ЕХ/Шенгений орнуудад хүчин төгөлдөр гадаадын паспорттой зорчино. Чех Улсаас эсвэл бусад гишүүн орноос олгосон оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг ЕХ-ы орнуудаар зорчих баримтад тооцохгүй.



Хэрэв та Чех Улсад удаан хугацааны виз, оршин суух зөвшөөрөл авсан, мөн хүчин төгөлдөр гадаад паспорттой бол Шенгений бусад орнуудаар зорчих боломжтой хэдий ч эдгээр орнуудын нутаг дэвсгэр дээр нийт 180 өдрийн дотор 90 хоног л саатах эрхтэй. Шенгений орнуудад саатаж болох нийт 180 өдрийн 90 хоногийн тооны машиныг [https://ec.europa.eu/home-](https://ec.europa.eu/home-affairs/content/visa-calculator_en)

[affairs/content/visa-calculator\\_en](https://ec.europa.eu/home-affairs/content/visa-calculator_en) цахим хуудаснаас үзэж болно. Шенгений орнуудын тоонд ордоггүй ЕХ-ы орнуудад хэрхэн зорчих тухай мэдээллийг тухайн орны дипломат төлөөлөгчийн газраас лавлах нь зүйтэй. Тухайн улсын хилээр нэвтрэх, түүнчлэн нисэх онгоцны буудлын дамжин өнгөрөх хэсэгт орохын тулд виз шаардагддаг байж магад. Чех Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн газрын жагсаалтыг Гадаад харилцааны яамны [www.mzv.cz](http://www.mzv.cz) цахим хуудаснаас үзнэ үү.

Уг сэдэвтэй холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим хуудасны “Гуравдагч орны иргэд – ЕХ/Шенгений орнуудад зорчих” хэсгээс үзнэ үү.

## ЧЕХ УЛСАД ГЭР БҮЛЭЭ АВЧИРАХ ТОХИОЛДОЛД

### Урилгын дагуу богино хугацааны виз олгох

Таны урилгаар Чех Улсад богино хугацаагаар ирэх гэж буй гэр бүлийн гишүүд эсвэл бусад этгээд нь БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газарт шенгений виз (90 хүртэлх хоногийн богино хугацааны виз) мэдүүлнэ. Урьж буй этгээд нь өөрийн оршин суугаа хаягийн дагуу харьяалагдах Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газраас авсан урилгын маягтыг бөглөж тус цагдаагийн газраар баталгаажуулна.

Танай гэр бүлийн гишүүд виз мэдүүлэхдээ дараах материалыг бүрдүүлж, гадаад улсаас олгосон бичиг баримтыг чех хэлээр орчуулсан албан ёсны орчуулгын хамт хавсаргана. Үүнд,

- Цагдаагийн байгууллагаар баталгаажуулсан урилгын маягт (бөглөсөн);
- Уригдаж буй этгээд нь визийн хугацаа дуусахаас өмнө Чех Улсын/Шенгений орнуудын нутаг дэвсгэрээс гарч явахаа нотолсон галт тэрэг, нисэх онгоцны тийз, санхүүгийн эх үүсвэрийн нотолгоо, ажлын тодорхойлолт, үл хөдлөх хөрөнгө эзэмшигчийн гэрчилгээ, гэр бүлийн баталгаа, хөдөлмөрийн харилцаатай болохоо нотлох баримт гэх мэт;
- Чех Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчлэх эрүүл мэндийн даатгалд даатгуулсан тодорхойлолт.



## “Гэр бүлийн” шалтгаанаар олгох удаан хугацааны виз

Хэрэв та Чех Улсад удаан хугацааны визээр оршин суудаг эсхүл гэр бүл нэгтгэх зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгох нөхцлийг хангаагүй хэдий ч (доорхийг үзнэ үү) танай гэр бүлийн гишүүд “гэр бүлийн шалтгаанаар” удаан хугацааны виз мэдүүлэх эрхтэй. Гэр бүлийн гишүүдийнхээ хэрэгцээг хангахад шаардагдах санхүүгийн эх үүсвэртэй эсэхээ сайтар тооцоол. “Гэр бүлийн” шалтгаанаар мэдүүлсэн визийн хариу 120 хоног үргэлжлэх нь тохиолддог.

Танай гэр бүлийн гишүүд энэ төрлийн виз мэдүүлэхдээ дараах материалыг бүрдүүлж, гадаад улсаас олгосон бичиг баримтыг чех хэлээр орчуулсан албан ёсны орчуулгын хамт хавсаргана. Үүнд,

- Нэг гэр бүлийн гишүүд гэгдийг нотлох төрсний гэрчилгээ, гэрлэгсдийн баталгаа,
- Гадаад паспорт,
- 1 хувь цээж зураг,
- Чех Улсад оршин суух байрны бичиг,
- Санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байхаас гадна түүнийгээ Чех Улсын нутаг дэвсгэр дээр ашиглах боломжтой гэдгийг нотлох баримт,
- Харьяат эсвэл сүүлийн 3 жил тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар амьдарсан улсын эрх бүхий байгууллагаас олгосон ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаа (БНЧУ-ын ЭСЯ-ны хүсэлтээр бүрдүүлнэ). Олон улсын гэрээнд уг үүргээс чөлөөлөөгүй бол ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаанд консулын баталгаажуулалт эсвэл апостиль гэрчилгээ хийлгэх шаардлагатай.
- халдварт өвчин тараахаас сэргийлэх нөхцөл болзлыг хангасан тухай тодорхойлолт (БНЧУ-ын ЭСЯ-ны хүсэлтээр бүрдүүлнэ).
- Чех Улсад оршин суух хугацаанд эрүүл мэндийн даатгалтай болохоо бичгээр нотлоно. Холбогдох байгууллагын хүсэлтээр даатгалын төлбөрийн баримтыг бүрдүүлнэ.

Танай гэр бүлийн гишүүдийг виз мэдүүлэхэд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим хуудасны “Гуравдагч орны иргэд – 90 хүртэл хоногийн виз” хэсгээс өөрөө **судлана уу**. Гэр бүлээ санхүүгийн хувьд хангах чадвартай эсэхээ сайтар тооцоолж үзэх нь чухал.



## Гэр бүл нэгтгэх зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрөл хүсэх

Хэрэв та удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй, Чех Улсад 15 сараас доошгүй хугацаанд амьдарсан эсхүл ажилтны карттай, тус улсад 6 сараас дээш хугацаанд амьдарсан тохиолдолд танай гэр бүлийн гишүүд гэр бүл нэгтгэх зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах эрхтэй. Энэ тохиолдолд ч мөн адил гэр бүлээ санхүүгийн хувьд хангах чадвартай эсэхээ та сайтар тооцоолж үзээрэй. Танай гэр бүлийн сар тутмын орлого нь ам бүлийн гишүүн бүрд оногдох амьжиргааны доод түвшний нийт дүнг байрны сарын түрээстэй нийлүүлснээс давж байх журамтай. Энэ төрлийн зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх хугацаа 270 хоног үргэлжилж болно.

Танай гэр бүлийн гишүүд хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж, гадаад улсаас олгосон бичиг баримтыг чех хэлээр орчуулсан албан ёсны орчуулгын хамт хавсаргана. Үүнд,

- Нэг гэр бүлийн гишүүд гэгдийг нотлох төрсний гэрчилгээ, гэрлэгсдийн баталгаа,
- Чех Улсад оршин суух байрны бичиг,
- Өөрийгөө болон гэр бүлээ тэжээхэд шаардагдах тогтмол болоод дор хаяж хуульд заасан хамгийн доод хэмжээний орлоготой болохоо нотлох,
- Чех Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх эрүүл мэндийн даатгалд даатгуулсан тодорхойлолт,
- Харьяат улсын цагдаагийн газраас олгосон ял шийтгэл эдэлж байсан эсэх лавлагаа (БНЧУ-ын ЭСЯ-ны хүсэлтээр бүрдүүлнэ),
- халдварт өвчин тараахаас сэргийлэх нөхцөл болзлыг хангасан тухай тодорхойлолт (БНЧУ-ын ЭСЯ-ны хүсэлтээр бүрдүүлнэ).

Гэр бүлийн гишүүд виз мэдүүлэхэд тавигддаг шаардлага, бүрдүүлэх материалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим хуудасны “Туравдагч орны иргэд – Удаан хугацааны зөвшөөрөл – Гэр бүл нэгтгэх зорилго” хэсгээс өөрөө судлана уу. Гэр бүлээ санхүүгийн хувьд хангах чадвартай эсэхээ сайтар тооцоолж үзэх нь чухал.

### ДАРААХ ЗҮЙЛИЙГ АНХААРНА УУ.

- Танай гэр бүлийн гишүүд удаан хугацааны виз, удаан хугацааны зөвшөөрлийн алиныг ч хүсэх эрхтэй (жич, удаан хугацааны зөвшөөрөл авах хүсэлтийг таныг Чех Улсад 15 эсвэл 6 сар амьдарсны дараа гаргана). Эхний ээл-

жинд удаан хугацааны визийг 1 жилээс дээшгүй хугацаагаар олгодог бол удаан хугацааны зөвшөөрлийг 2 жилээс дээшгүй хугацаагаар олгодог.

- Хэрэв танай гэр бүлийн гишүүд гэр бүл нэгтгэх зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрөл аваад зогсохгүй Чех Улсад ирсний дараа өөртөө тохирох ажлын байр олох тохиолдолд тус улсад оршин суух хугацаандаа хөдөлмөрийн зөвшөөрөл, ажилтны карт авалгүй ажиллах эрхтэй.
- Чех Улсад гэр бүлээрээ нэг дор амьдрах шийдвэр гаргахаасаа өмнө тэднийхээ бүх талын хэрэгцээг хангах хангалттай орлоготой гэдгээ баттай тооцоолсон байх хэрэгтэй. Танай гэр бүлийн гишүүд виз мэдүүлэх, удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах үедээ таны гаргасан нотлогоог бусад материалын хамт бүрдүүлнэ.
- Чех Улсад 90-ээс дээш хоног амьдарч буй (Чех Улсад богино хугацаагаар зочилсон хүүхдэд хамаарахгүй) **6-15 хүртэлх насны хүүхдийг ерөнхий боловсрол эзэмшүүлэхийн тулд бага сургуульд, 5 настай хүүхдийг цэцэрлэгт заавал хамруулах үүрэгтэй.** Энэ үүргээ зөрчсөн этгээдэд хариуцлага тооцно.

## ЧЕХ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛ

Чех Улсад оршин суудаг, зорчиж буй хүн бүр эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулах үүрэгтэй.

Эрүүл мэндийн даатгал нь нийтийн болон гэрээт гэсэн хоёр төрөл байдаг.

**Нийтийн эрүүл мэндийн даатгалд** гадаадын иргэд дараах нөхцөлд хамрагдана. Үүнд,

- Байнга оршин суух зөвшөөрөлтэй бүх гадаадын иргэд,
- Виз, оршин суух зөвшөөрлийн төрлөөс үл хамааран Чех Улсад албан ёсны хаяг бүхий ажил олгогчийн ажилтан (даатгалыг ажил олгогч төлдөг),
- ЕХ-ы гишүүн орны иргэд, тодорхой нөхцөлд тэдний гэр бүлийн гишүүд,
- Олон улсын хамгаалалд хамрагсад зэрэг зорилтот бүлгийн хүмүүс

**Эрүүл мэндийн гэрээт даатгал (бас гадаадад зорчигчдийн эрүүл мэндийн даатгал гэдэг)** нь аль нэгэн даатгалын компани, даатгуулагч хоёрын хооронд байгуулсан хувийн эрх зүйн харилцааг хэлэх бөгөөд байнга оршин

суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдээс бусад гадаадын иргэдэд хамаатай. Үүнд,

- бизнес эрхлэгч (“ОСВЧ”/“OSVČ”) болон бусад хувиараа орлого олох үйл ажиллагаа эрхлэгч,
- хөдөлмөр эрхэлдэг ажилтнууд, бизнес эрхлэгчдийн гэр бүлийн орлогогүй гишүүд,
- оюутнууд



90 хүртэлх хоногийн шенгений визээр зорчигчдын эрүүл мэндийн даатгалд тавигдах шаардлагыг Европын Холбооны “Визийн кодекс” удирдамжаар зохицуулдаг.

БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газарт удаан хугацааны виз эсвэл оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргасан гадаадын иргэн эрүүл мэндийн яаралтай үйлчилгээний зардлыг багтаасан даатгалд заавал хамрагдах үүрэгтэй бөгөөд энэ төрлийн даатгал нь өвдсөн эсвэл нас барсан тохиолдолд цогцосыг нь нутаг руу нь буцаах тээврийн зардлыг багтаадаг. Даатгалын нэг удаагийн тохиолдолд ноогдох даатгалын олговрын хэмжээ 60 000 ЕВРО-оос багагүй байна. Гадаадад зорчигчдын эрүүл мэндийн даатгалд тухайн этгээдийн санаатай, санаандгүй үйлдсэн үйлдэл эрүүл мэндэд нь учирсан хохирол, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсний улмаас үүссэн хохирлыг ч багтаасан байх шаардлагатай.

Чех Улсад оршин сууж байх үедээ удаан хугацааны виз, удаан хугацааны зөвшөөрөл, уг зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан гадаадын иргэн нь эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээ хамарсан гэрээт даатгалд даатгуулах

үүрэгтэй. Энэ нь даатгуулагчийн эрүүл мэндийн байдлыг хэвийн байлгах үүднээс даатгалын гэрээ байгуулахаас өмнөх үеийг хамарсан эрүүл мэндийн үйлчилгээг бэлэн мөнгөний тооцоо хийхгүй үзүүлнэ гэсэн үг юм. Иж бүрэн даатгалд урьдчилан сэргийлэх үзлэг, хэвтэж эмчлүүлэх, жирэмслэлт, амаржихтай холбогдсон эрүүл мэндийн үйлчилгээг оруулах шаардлагатай. Эрүүл мэндийн иж бүрэн даатгалын гэрээг зөвхөн Чех Улсын нутаг дэвсгэр дээр эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий компанитай байгуулна.

Хэрэв эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлаа олон улсын гэрээний дагуу эсвэл хуулийн этгээд, төрийн байгууллагын бичгээр үйлдсэн баталгаа, цагдаагийн газраас баталгаажуулсан урилгаар уригч этгээд нь хүлээсэн үүргийнхээ дагуу өөр хэлбэрээр даана гэдгээ нотловол эрүүл мэндийн гэрээт даатгалын баримт шаардахгүй.

Хөдөлмөр эрхлэдэг гадаадын иргэний өмнөөс ажил олгогч **нийгмийн даатгалыг нь төлдөг**. Бизнес эрхэлдэг гадаадын иргэн нийгмийн даатгалаа өөрөө төлөх үүрэгтэй.

Чех Улсын хууль тогтоомжид заасан ёсоор эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдаагүй тохиолдолд виз, оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзах эсвэл нэгэнт олгосон виз, оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгож болзошгүй.

## **ГАДААДЫН ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ДАСАН ЗОХИЦОХ, ИНТЕГРАЦИЛАЛЫН ДАМЖАА**

2021.01.01-ний өдрөөс эхлэн зорилтот бүлгийн гадаадын иргэдэд **оршин суух зөвшөөрөл олгох шийдвэр нь хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн нэг жилийн дотор дасан зохицох, интеграцчилалын дамжаанд хамрагдах үүрэг шинээр нэмэгдэж байна**. Дөрвөн цаг үргэлжлэх энэхүү дамжаанд сууснаар оролцогчид Чех Улсад оршин суухтай холбогдох эрх, үүрэгтэй танилцана.

### **Хэн дамжаанд хамрагдах үүрэгтэй вэ?**

Дасан зохицох, интеграцчилалын дамжаанд 2021.01.01-ний өдрөөс эхлэн

- Чех Улсад удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авсан,
- Чех Улсад оршин суух зорилго өөрчлөгдсөн шалтгаанаар удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авсан,

- орогнох эрх авсан гадаадын иргэнтэй Чех Улсын нутаг дэвсгэрт нэвтэрхээс өмнө гэр бүл болсон эхнэр нөхөр, орогнох эрх авсан гадаадын иргэний насанд хүрээгүй эсвэл түүнээс хамааралтай орогнох эрх авах хүсэлт гаргаагүй хүүхэд, өмнө нь Чех Улсын иргэн байсан гадаадын иргэн хүмүүнлэгийн шалтгаанаар Чех Улсад байнга оршин суух зөвшөөрөл авсан,
- онцгой шалтгаанаар Чех Улсад байнга оршин суух зөвшөөрөл авсан,
- тус улсад оршин суух нь Чех Улсын ашиг сонирхолд нийцсэн гадаадын иргэн байнга оршин суух зөвшөөрөл авсан,
- эцэг, эх нь Чех Улсад байнга оршин суух зөвшөөрөл авсан ба хүүхэд нь гэр бүл нэгтгэх зорилгоор байнга оршин суух зөвшөөрөл авсан,
- тасралтгүй зургаагаас дээш жил Чех Улсаас гадуур, тасралтгүй арван хоёр сараас дээш хугацаагаар ЕХ-ноос гадуур амьдарсан шалтгаанаар Чех Улсад байнга оршин суух зөвшөөрөл нь хүчингүй болсон тохиолдолд шинээр байнга оршин суух зөвшөөрөл авсан,
- олон улсын хамгаалал олгох ажиллагаа нь дууссан тус улсад тасралтгүй дөрвөн жил амьдарсны дараа байнга оршин суух зөвшөөрөл авсан

гадаадын иргэн бүр хамрагдах үүрэгтэй.

## **Хэн дамжаанд хамрагдахгүй байж болох вэ?**

**Европын Холбооны орнуудын иргэд**, тэдний гэр бүлийн гишүүд, Чех Улсын иргэний гэр бүлийн гишүүд дасан зохицох, интеграцчилалын дамжаанд хамрагдахгүй.

Мөн түүнчлэн

- сурах зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авсан,
- хамгааллын зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авсан,
- хөрөнгө оруулах зорилгоор тус улсад удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авсан
- БНЧУ-ын Гадаад харилцааны яамнаас удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авсан,
- компани дотроо шилжүүлсэн ажилтны карт авсан,
- компани дотроо шилжүүлсэн Европын Холбооны өөр орны ажилтны карт авсан

Чех Улсад оршин сууж байгаа гадаадын иргэд уг дамжаанд хамрагдахгүй.

Цаашилбал, Чех Улсад оршин суух зөвшөөрөл олгох шийдвэр нь хүчин төгөлдөр болсон өдрийн байдлаар 15 нас хүрээгүй эсвэл 61 нас хүрсэн гадаадын иргэд, түүнчлэн 2021.01.01-ний өдрөөс хойш уг дамжааг дүүргэсэн гадаадын иргэд дасан зохицох, интеграцчилалын дамжаанд суух шаардлагагүй.

“Мэргэжлийн өндөр түвшний ажилтан”, “Нэн шаардлагатай болон эрдэм шинжилгээний ажилтан” хөтөлбөрийн хүрээнд олгосон ажилтны болон цэнхэр карт эзэмшигчид уг дамжаанд хамрагдахгүй.

Дасан зохицох, интеграцчилалын дамжааг дүүргээгүй явдлыг зөрчилд тооцох тул **10 000 крон хүртэлх** торгууль ногдуулна.

### **Дамжаанд заавал хамрагдах үүргээ үл ойшоох тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?**

Дасан зохицох, интеграцчилалын дамжааг дүүргээгүй явдлыг зөрчилд тооцох тул **10 000 крон хүртэлх** торгууль ногдуулна.

### **Дамжаа хаана болдог вэ?**

**ЗӨВХӨН** Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төвөөс зохион байгуулж буй дамжаанд сууна ([www.integracnicentra.cz](http://www.integracnicentra.cz)). АНХААР! Ижил төстэй нэртэй боловч өөр газраас зохион байгуулсан дамжаанд суусан тохиолдолд үүргээ биелүүлсэнд тооцохгүй. **ЗӨВХӨН** <https://frs.gov.cz> цахим хуудаар бүртгүүлж, зохих төлбөрийг төлсний дараа дамжаа болох огноо, газрын тухай мэдээлэл **олж авах боломжтой**. Гадаадын иргэний дасан зохицох, интеграцчилалын дамжаанд хамрагдах төлбөр **1 500 чех крон** болно.

### **Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс олж авна уу:**

[www.vitejtevcr.cz](http://www.vitejtevcr.cz)



# ЮУГ АНХААРАХ ВЭ? ЯМАР ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?

Өмнөд Морава дахь Валтице шилтгээн

## ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ТУСЛАЛЦАА, МЭДЭЭЛЭЛ

- Шаардлагатай тохиолдолд Интеграцчилалын төв, төрийн бус байгууллагуудад хандах хэрэгтэй. Эдгээр байгууллага нь танд үнэ төлбөргүй тусалцаа өгөхөөс гадна хууль зүйн болон нийгмийн асуудлаар зөвлөгөө өгөх үүрэгтэй.
- Эдгээр байгууллагад хандахаасаа өмнө төрийн байгууллагуудын цахим хуудас руу орж найдвартай мэдээлэл олж авах нь чухал. Жишээ нь: **www.mvcr.cz/cizinci** эсвэл **www.mpsv.cz/web/cz/prace-a-zamestnani#prace-cizincu** Интернетээс олж авсан мэдээллээ хангалтгүй гэж үзвэл зөвлөгөө өгөх төвд цаг захиална. Та мэдэж авах шаардлагатай зүйлээ бүгдийг нь дэс дараалан бичиж, асуух асуултын жагсаалт гарга. Товлосон цагтаа очихдоо бэлдсэн асуултын жагсаалтаас гадна ерөөсөө зөвлөгөө авахад хэрэгтэй гэж үзсэн бичиг баримтаа бүгдийг нь авч очих хэрэгтэй.
- Мэргэжлийн байгууллагаас үнэ төлбөргүй тусалцаа авсан тохиолдолд тулгарсан асуудлаа бие даан хялбар замаар шийдвэрлэх боломжтой болно.

## ЗУУЧЛАГЧ КОМПАНИУД

- Та Чех Улс руу явах, оршин суух асуудлаа өөрөө хөөцөлдөх боломжтой тул бусдад зуучлалын мөнгө төлөх шаардлагагүй! БНЧУ-ны дипломат төлөөлөгчийн газар, Дотоод хэргийн яамны гадаадын иргэдэд зориулсан албан ёсны цахим хуудас, Интеграцчилалын төвүүд, төрийн бус байгууллагуудын шугамаар найдвартай мэдээлэл олж авахыг хичээгтүн. Албан ёсны цахим хуудаснаас бусад эх үүсвэрээс олж авсан мэдээлэлд зуун хувь итгэж болохгүй.
- Хэрэв та зуучлалын компанийн (агентурын) үйлчилгээ авч байгаа бол уг компани нь хөдөлмөр зуучлах хүчин төгөлдөр эрхтэй эсэхийг нь нягтлах шаардлагатай. Магадлан итгэмжлэгдсэн хөдөлмөр зуучлалын компани, агентурын жагсаалтыг Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны **www.mpsv.cz/web/cz/prace-a-zamestnani#agentury-prace** цахим хуудаснаас үзнэ үү.

## БИЕЙН БАЙЦААЛТ, БИЧИГ БАРИМТ

- Биеийн байцаалт, гадаад паспортоо хэзээ ч бусдад өгч болохгүй. Чухал бичиг баримтынхаа хуулбарыг нотариатаар баталгаажуулахаас гадна өөрийнхөө болон тантай хамт яваа хүүхдүүдийнхээ боловсролын гэрчилгээ, вак-



цинжуулалтын товлолын дэвтэр, шаардлагатай бусад чухал бичиг баримтыг Чех Улсад зорчихдоо заавал биедээ авч явах хэрэгтэй.

- БНЧУ-д оршин суух зөвшөөрлийн цахим үнэмлэхээ гээж, гэмтээсэн тохиолдолд үнэмлэх шинээр гаргуулах төлбөр маш өндөр тул сайтар хамгаалж, хадгалагтун.

## ИТГЭМЖЛЭЛ

- Та өөрөө хөөцөлдөх боломжтой эсвэл өөрөө биечлэн хөөцөлдөхөөс өөр аргагүй жишээлбэл, гэрээнд гарын үсэг зурах, албан захидал хүлээн авах зэрэг асуудлаар ерөнхий итгэмжлэл үйлдэн бусдад өгч огт болохгүй. Итгэмжлэлийг тодорхой үйлдэл хийлгэх зорилгоор, тодорхой хугацаатай, тодорхой этгээдэд өөрийгөө төлөөлүүлэхээр олгодог.



- Хэрэв та өөрийгөө төлөөлүүлэн бусдад итгэмжлэл өгөх болсон бол хамгийн найдвартай гэж итгэсэн хүндээ өгөх ба итгэмжлэлийнхээ нэг хувийг заавал өөртөө авч үлд. Зөвхөн өмгөөллийн лиценз эзэмшдэг өмгөөлөгч л бусдыг төлөөлөх төлбөртэй үйлчилгээ үзүүлэх эрхтэй. Итгэмжлэл өгч бусдаар хөөцөлдүүлсэн асуудал тань хэрхэн шийдвэрлэгдсэн тухай асууж лавла. Танд эргэлзээтэй санагдсан тохиолдолд асуудлыг тань шийдвэрлэж байгаа байгууллагад шууд хандах хэрэгтэй. Итгэмжлэлийг дуртай үедээ цуцлах боломжтой.
- Ажлын холбогдолтой гэрээ, хэлэлцээрийг ямагт бичгээр байгуулж, баримт бичгээ нэгбүрчлэн найдвартай сайн хадгалах нь маргаан үүссэн тохиолдолд танд эрхээ хамгаалуулах боломжийг олгодог.

## АЖЛЫН НӨХЦӨЛ

- Чех Улсад орж ирэхээсээ өмнө гүйцэтгэх ажлынхаа агуулга, нөхцлийн талаар ажил олгогчтой урьдчилан бичгээр тохиролцох шаардлагатай.



- Таныг Чех Улсад ирсний дараа ажил олгогч тохиролцноос өөр, тэвчишгүй хөдөлмөр хийлгүүлсэн тохиолдолд энэ нь залилан мэхлэх эсхүл бүр хөдөлмөрийн мөлжлөг хийх зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн байж болох юм. Энэ нь эрэгтэй эмэгтэй ямар ч хүнд хүйс харгалзахгүй тохиолдож болох бөгөөд ийм гэмт хэрэг хүнтэй ёс бус харьцах, хэтэрхий олон цагаар ажиллуулах, эрүүл ахуйн шаардлага хангаагүй аюултай нөхцөлд, эрүүл мэндэд хортой ажил хийлгүүлэх, тэвчишгүй хүнд нөхцөлд ажиллуулах, зохиомол өр албадан төлүүлэх, сэтгэл санааны дарамт, бэлгийн мөлжлөгт оруулсан зэрэг шинжийг агуулдаг. Ийм тохиолдолд та нэн даруй тусгай ТББ (Холбоо барих хэсгээс үзнэ үү) эсвэл БНЧУ-ын Цагдаагийн газарт хандаж өөрийгөө хамгаалуулах нь зүйтэй. Та гэрчийн мэдүүлэг өгснөөр гэмт хэрэгтэнд хариуцлага тооцож таны нэгэн адил бусад гадаадын иргэдийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх боломж олгоно.

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч Чех Улсын хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажилласан тохиолдолд тус улсад хамгаалах зорилгоор оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах эрхтэй бөгөөд ингэснээр та тус улсад оршин суух эрхээ алдахгүй.

## ӨР ТӨЛБӨР, ӨР ТӨЛБӨРГҮЙ БАЙХ ТУХАЙ

- Өр төлбөр тавьж шүүхийн шийдвэрээр эд хөрөнгөө хураалгах нь таныг зөвхөн мөнгө санхүүгийн хувьд хүнд байдалд оруулаад зогсохгүй таныг тус улсад хууль бусаар оршин суух байдалд ч хүргэж болох аюултай тул аль болох мөнгө зээлэхээс болгоомжил. Хэдийгээр ноцтой бус мэт боловч нийтийн тээврээр тасалбаргүй зорчсон торгууль, телевиз, радио, хог хаягдал зайлуулсан хураамж, зээлээр худалдаж авсан бараа, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүйн улмаас торгууль ноогдуулж алданги тооцож болзошгүй.

- Чех Улсад өртэй этгээдийн бүртгэл байдаг. Бизнес эрхлэх, оршин суух зөвшөөрлөө шийдүүлэхэд өр төлбөргүй байх шаардлагатай.

## УУЛЬ САХИЖ МӨРДӨХ

- Оршин суух, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжоос гадна Чех Улсад үйлчилж буй өөр бусад хууль тогтоомжийг зөрчвөл таныг зөвхөн тус улсаас гаргаад зогсохгүй Шенгений мэдээллийн системд (SIS) оруулж болзошгүй. Ийм тохиолдолд та Шенгений гэрээний орнуудад зорчих эрхээ хасуулна гэсэн үг.

## ЧЕХ УЛСАД ОРШИН СУУГАА ХАЯГАА ӨӨРЧИЛСӨН ТОХИОЛДОЛД

Чех Улсад оршин суугаа гэрийн хаягаа өөрчилж нүүсэн тохиолдолд энэ тухайгаа хуульд заасан хугацааны дотор мэдэгдэх үүрэгтэй. Албан байгууллагаас танд баталгаат захидал явуулсан тохиолдолд та эзгүй байж таарвал шүүдан хүргэгч албан захидлыг хүргээгүй тухай мэдэгдлийг танай шуудангийн хайрцганд үлдээнэ. Шуудангийн салбарт хадгалагдаж буй захидлыг та 10 хоногийн дотор очих авах бөгөөд хэдийгээр захидлаа шуудангийн салбараас очиж аваагүй ч заасан хугацааны сүүлийн өдрөөр захидлыг хүргүүлсэнд тооцдог. Шуудан хүргэгч таныг олоход дөхөм болгох үүднээс шуудангийн хайрцаг, гадаа хаалганы дэргэд байрлуулсан хонхон дээр овог нэрээ бичих нь чухал.

## ОНЦГОЙ ТОХИОЛДОЛД ХЭРЭГЛЭХ ҮҮДНЭЭС МӨНГӨ ХУРИМТЛУУЛАХ

Та гэнэтийн хүндрэл гарах, нутаг буцах зэрэг тохиолдолд тодорхой хэмжээний санхүүгийн нөөцтэй болохын тулд санхүүгийн боломж таатай байгаа үедээ мөнгө болж өгвөл цааш нь хадгалах нь зүйтэй.



# ЧЕХ УЛСАД ХОЛБОО БАРИХ ЧУХАЛ ХАЯГ, УТАС

Марианске Лазне хотын дэргэдэх Тепла тосгон  
дахь Премонстрантуудын хийдийн үзэмж

## ЧЕХ УЛС РУУ ЯВАХААС ӨМНӨ:

### **БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газар, Шенгений виз олгох:**

- **БНЧУ-ын Гадаад харилцааны яам** – Визийн хэлтэс  
[www.mzv.cz](http://www.mzv.cz), и-мейл: [vo@mzv.cz](mailto:vo@mzv.cz)

## ЧЕХ УЛСАД ОРЖ ИРСНИЙ ДАРАА:

### **Оршин суухтай холбоотой аливаа асуудал, оршин суух хугацаа сунгуулах, өөрчлөлт мэдэгдэх:**

- **БНЧУ-ын Дотоод хэргийн яам:** Орогнол, шилжин сууршилтын бодлогын газар (чехээр “ОАМП”/ “ОАМР” гэж товчлоно)

[www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) – эндээс Дотоод хэргийн яамны бүс нутаг дахь салбар хэлтсийн хаягийг олж авах боломжтой

Мэдээллийг дараах утас, и-мейлээр авна:

Дотоод хэргийн яамны лавлах утас (чех хэлээр): утас: (+420) 974 820 680

### **Оршин суух эрхийн хяналт, урилга баталгаажуулалт, тус улсад орж ирсэн гадаадын иргэдийн бүртгэл:**

- **БНЧУ-ын Цагдаагийн газар – Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар**  
[www.policie.cz/clanek/agenda-cizinecke-policie.aspx](http://www.policie.cz/clanek/agenda-cizinecke-policie.aspx)

### **Чех Улсад хөдөлмөр эрхлэх, мэдээлэл, зуучлагч компани, агентур, (гадаадын иргэд ч ажиллаж) болох сул ажлын байрны зар:**

- **Хөдөлмөр, нийгмийн хэргийн яам**

Гадаадын иргэд Чех Улсад хөдөлмөр эрхлэх тухай: [www.mpsv.cz/web/cz/prace-a-zamestnani#prace-cizincu](http://www.mpsv.cz/web/cz/prace-a-zamestnani#prace-cizincu)

Хөдөлмөр зуучлагч компани, агентурын тухай мэдээлэл:  
[www.mpsv.cz/web/cz/prace-a-zamestnani#agentury-prace](http://www.mpsv.cz/web/cz/prace-a-zamestnani#agentury-prace)

Хөдөлмөрийн товчоо: [www.uradprace.cz/web/cz/kontakty-2](http://www.uradprace.cz/web/cz/kontakty-2)

Хөдөлмөр хяналтын газар: [www.suip.cz/](http://www.suip.cz/)

## **Үнэ төлбөргүй мэдээлэл, зөвлөх үйлчилгээ:**

### **• Интеграцчилалын төвүүд - [www.integracnicentra.cz](http://www.integracnicentra.cz)**

Чех Улсын аймаг бүрт шахуу интеграцчилалын төв ажилладаг. Интеграцчилалын төвд таны асуудлыг ямар байгууллага шийдэх талаар үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, чех хэлний дамжаа санал болгох, зөвлөгөө өгөх, орчуулах, хэлмэрчлэх зэрэг олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг. Интеграцчилалын төвүүдэд үнэ төлбөргүй интернет ашиглах боломжтой бөгөөд ажилтнууд нь интернет хэрхэн ашиглах талаар зөвлөгөө өгч, тусалцаа үзүүлдэг.

### **• Төрийн бус байгууллагууд (ТББ) - [www.cizinci.cz](http://www.cizinci.cz)** цахим хуудасны Холбоо барих хэсгээс ТББ-ын хаяг, холбоо барих утасны дугаарыг лавлах боломжтой.

ТББ нийгмийн болон хууль эрх зүйн асуудлаар зөвлөх үйлчилгээ, чех хэлний сургалт, албан газартай харьцах, албан газарт очих, эмчид үзүүлэх, сургууль, багш нартай уулзах үед хамт явах, орчуулга хийх зэрэг үйлчилгээг төлбөргүй үзүүлдэг. Тусалцаа, зөвлөгөө хэрэгтэй болсон тохиолдолд заавал гэрийн хаягийн дагуу гэлтгүй дуртай ТББ-д утсаар хандах боломжтой. Биечлэн очиж зөвлөгөө авах тохиолдолд бүс нутагт үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагуудад хандана.

## **Төрийн бус байгууллагуудын заримаас нь дурдвал:**

### **• Дүрвэгсдэд туслах байгууллага/Organizace pro pomoc uprchlíkům ("ОПУ"/"ОРУ")** – хууль эрх зүйн болон нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – [www.opu.cz](http://www.opu.cz), утас: (+420) 730 158 779, (+420) 739 413 983 (нийгмийн асуудлаар), (+420) 730 158 781, (+420) 730 158 779 (хууль зүйн асуудлаар), и-мейл: [opu@opu.cz](mailto:opu@opu.cz)

### **• Интеграцчилалын асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх төв/ Poradna pro integraci ("ППИ"/"РРІ")** – хууль эрх зүйн болон нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – [www.p-p-i.cz](http://www.p-p-i.cz), утас: (+420) 603 281 269 (нийгмийн асуудлаар), и-мейл: [paha@p-p-i.cz](mailto:paha@p-p-i.cz)



- **International Organization for Migration (Шилжин сууршилтын олон улсын байгууллага/Mezinárodní organizace pro migraci – “АЙОМ”/“ИОМ”)** – зөвлөх үйлчилгээ, хөдөлмөрийн шилжин сууршилт, сайн дураар нутаг буцах хөтөлбөр – [www.iom.cz](http://www.iom.cz), утас: (+420) 775 965 573, и-мэйл: [prague@iom.int](mailto:prague@iom.int)
- **Гадаадын иргэдийн итеграцилалын төв/Centrum pro integraci cizinců (“ЦИЦ”/“СІС”)** – хөдөлмөр, нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – [www.cicpraha.org](http://www.cicpraha.org), утас: (+420) 222 360 452, (+420) 704 600 700 (нийгмийн асуудлаар), (+420) 702 150 630 (хөдөлмөрийн асуудлаар), и-мэйл: [info@cicpraha.org](mailto:info@cicpraha.org)
- **Интеграцилал, шилжин сууршилтын нийгэмлэг/Sdružení pro integraci a migraci (“СИМИ”/“SIMI”)** - хууль эрх зүй, нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – [www.migrace.com](http://www.migrace.com), утас: (+420) 605 253 994 (нийгмийн асуудлаар), +420 603 547 450 (хууль зүйн асуудлаар), и-мэйл: [poradna@migrace.cz](mailto:poradna@migrace.cz)
- **ИнБазе/InBáze, z.s.** – хууль зүй, ниймийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – [www.inbaze.cz](http://www.inbaze.cz), утас: (+420) 739 037 353, и-мэйл: [info@inbaze.cz](mailto:info@inbaze.cz)
- **Чех Улсын Харита/Charita ČR** – хүндрэлтэй нөхцөлд орсон гадаадын иргэдэд тусалцаа үзүүлдэг – [www.charita.cz](http://www.charita.cz) (монгол, вьетнам хэлээр [www.charita.cz/infolinka](http://www.charita.cz/infolinka)). Чех Улсын Харита-гийн салбар хэлтсүүд нь улс даяар ажилладаг.
- **Прага хот дахь Арцидиецезийн Харита - Шилжин сууршилтын төв/Arcidiecézní Charita Praha – Středisko Migrace** – Хууль зүй, нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг, хүндрэлтэй үед богино хугацаагаар хоноглох байраар хангах, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүмүүст тусалцаа үзүүлдэг – [www.praha.charita.cz](http://www.praha.charita.cz), утас: (+420) 224 246 573, и-мэйл: [migrace@praha.charita.cz](mailto:migrace@praha.charita.cz)
- **“МЕТА” олон нийтийн төлөөх компани/META, o.p.s.** – залуучууд, насанд хүрэгчдийн боловсрол, аттестат, дипломыг дүйцүүлэн баталгаажуулах асуудлаар зөвлөгөө, тусалцаа үзүүлдэг – [www.meta-ops.cz](http://www.meta-ops.cz), утас: (+420) 222 521 446, (+420) 773 304 464, и-мэйл: [info@meta-ops.cz](mailto:info@meta-ops.cz)

- **Чех Улсын Ла Страда/La Strada Česká republika** – хүн худалдаалах, бусдын эрхшээлд орсон хохирогчдод туслалцаа үзүүлдэг – [www.strada.cz](http://www.strada.cz), яаралтай дуудлагын SOS утас: (+420) 222 717171, Лавлах утас: (+420) 800 077 777

## **Европын Холбооноос гадаадын иргэдэд зориулсан цахим хуудас:**

- [www.ec.europa.eu/immigration](http://www.ec.europa.eu/immigration)

## **ДАРААХ ЗҮЙЛИЙГ МАРТУУЗАЙ**

### **Явахаасаа өмнө**

1. Өөрийн нэр дээр авсан гадаад паспорттой байх. 15 нас хүрээгүй хүүхэд өөрийн нэр дээр гадаад паспорт аваагүй тохиолдолд эцэг эх нь өөрсдийнхөө аль нэгний паспортод заавал бичүүлнэ. Удаан хугацааны виз олгуулахад гадаад паспортыг дээд тал нь 10 жилийн өмнө олгосон, паспортод хоёроос цөөнгүй цэвэр хуудас байх шаардлагатай байдгаас гадна паспортын хүчинтэй хугацааны доод тал нь удаан хугацааны визийн хугацаанаас 3 сараас дээш байна.
2. Виз мэдүүлэх, оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын тухай мэдээллийг БНЧУ-ын ЭСЯ-аас лавлан асуусан эсвэл [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci) цахим хуудаснаас үзсэн.
3. Чех Улсын нутаг дэсвгэрт үйлчилдэг эрүүл мэндийн даатгалд даатгуулсан байна.
4. Гадаад паспортод виз даруулсан эсвэл ЭСЯ-аас оршин суух зөвшөөрөл олгосон тухай мэдэгдэл авсан байна.

### **Чех Улсад орж ирсний дараа**

1. Гадаадын иргэнийг бүртгүүлэх үүрэгтэй зочид буудал, дотуур байрнаас өөр газар байрлаж байгаа тохиолдолд өөрөө бүртгүүлнэ. Чех Улсад визээр орж ирээд байгаа тохиолдолд ажлын 3 хоногийн дотор Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газарт биечлэн очиж бүртгүүлнэ. Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл хүссэн тохиолдолд Дотоод хэргийн яамны салбар, хэлтэст биечлэн очиж бүртгүүлнэ.



2. Удаан хугацааны оршин суух зөвшөөрөл хүссэн тохиолдолд Чех Улсад орж ирээд ажлын 3 хоногийн дотор Дотоод хэргийн яамны салбар, хэлтэст биеийн давхцахгүй өгөгдөл авахуулах зорилгоор биечлэн очих үүрэгтэй.
3. Биеийн давхцахгүй өгөгдөл авахуулсан бол заасан хугацааны дараа мөн газарт очиж бэлэн болсон үнэмлэхээ авч, зохих хураамж төлнө.

## **Чех Улсад оршин сууж буй хугацаанд**

1. Овог, гэр бүлийн байдал, гадаад паспорт болон оршин суух зөвшөөрөлд орсон мэдээлэл, Чех Улсад оршин сууж байгаа хаяг зэрэг өөрчлөгдсөн тухай бүр нь Дотоод хэргийн яамны салбар, хэлтэст заавал мэдэгдэх үүрэгтэй.
2. Тус улсад оршин суух эрхийн хугацаанаас илүү хугацаагаар үлдэхээр төлөвлөж байгаа бол цаг тухайд нь дараах хүсэлтийн аль нэгийг гаргана. Үүнд,
  - удаан хугацааны визийн хугацааг сунгуулах хүсэлт (визийн хүчинтэй байх хугацаа дуусахаас дээд тал нь 90, доод тал нь 0 хоногийн өмнө гаргана),
  - анх удаа удаан хугацааны зөвшөөрөл авч байгаа эсвэл өмнө авсан удаан хугацааны зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт (удаан хугацааны виз, удаан хугацааны зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа дуусахаас дээд тал нь 120, доод тал нь уг хугацаа дуусахаас өмнөх сүүлийн ажлын өдөр гаргана).
3. Чех Улсад оршин сууж байгаа хугацаандаа удаан хугацааны виз эсвэл оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргахдаа анх заасан зорилгоо өөрчлөөгүй хэвээр байх шаардлагатай.

**Холбоо барих:**

БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газар

БНЧУ-ын Гадаад харилцааны яам - [www.mzv.cz](http://www.mzv.cz), и-мейл: [vo@mzv.cz](mailto:vo@mzv.cz)

**Чех Улсад орж ирсний дараа:**

БНЧУ-ын Дотоод хэргийн яам: Орогнол, шилжин сууршилтын бодлогын газар  
("ОАМР"/ "ОАМП") - [www.mvcr.cz/cizinci](http://www.mvcr.cz/cizinci)

Лавлах утас: (+420) 974 820 680